

Аймгийн засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийн ХШҮ-ний тайлан

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

2024 оны хагас жил

| Д/д   | Зорилт   | Арга хэмжээ  | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая | 2024 оны зорилто | Нэгдсэн дүгнэлт   | Үнэлгэ э |
|---|--|--|------------------|---|------------------|---|----------|
| <b>1. НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b> |  |  |                  |   |                  |   |          |
| 1   | 1.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас | 1. Коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024      |   | 100              | Аймгийн Засаг даргын 2023 оны А/253 дугаар захирамжаар тус аймгийн хэмжээнд бүх төрлийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах чиглэлээр албадын бэлтгэл бэлэн байдлыг хангуулсан бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар коронавирусийн халдварын цар тахал дахин гарааргүй болно. | 100%     |
| 2   | хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана.   | 2. Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлтгэл, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах               | 2021 - 2024      |   | 100              | Тус газраас жил зохион байгуулдаг аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган 2 суманд 2024 оны сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна  | 70%      |

|   |   |   |             |  |    |  |     |
|---|---|---|-------------|--|----|--|-----|
| 3 | 1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, халдваргүйжүүлэх бодис, тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй нэмэгдүүлж, нөөцийг бүрдүүлнэ. | 1. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх | 2021 - 2024 |  | 95 | Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлуулж, 365.439.900 төгрөгийн төсөвт өртөгтэй, 17 багцтай худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, 266.698.600 төгрөгийн гэрээ байгуулсан. Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн судалгааг А/211 тушаалын дагуу ЭЭХХЗГ-т хүргүүлсэн. Аймгийн Онцгой комисст тухай бүрд эм, тариа, урвалж оношлуур, эмнэлгийн хэрэгслийн мэдээг хүргүүлсэн. Улсын их хурлын 2008 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хангах зорилгоор ЭЭХХЗГ-аас ирүүлсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн мэдээллийг 7 хоног бүрийн 2 дахь өдөр ЭЭХХЗГ-т хүргүүлж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл нийлүүлэгдэж, харъяа нэгжүүдэд хуваарилан ажилласан. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалт 90 хувьтай байна. | 70% |
|---|---|---|-------------|--|----|--|-----|

|   |  |   |                |  |    |  |     |
|---|--|---|----------------|--|----|--|-----|
| 4 | 1.1.3. Иргэдэд<br>коронавирусийн<br>халдвараас<br>урьдчилан<br>сэргийлэх ажлыг<br>эрчимжүүлэн<br>зохион байгуулна. | 1. Коронавирусийн<br>халдвараас урьдчилан<br>сэргийлэх олон талт<br>арга хэмжээний<br>төлөвлөгөө<br>боловсруулж,<br>хэрэгжилтийг хангах | 2021 -<br>2024 |  | 90 | Гамшгийн төлөвлөгөөнд тодотголоор<br>Ковидын халдвараас сэргийлэх төлөвлөгөө<br>батлуулан хавсаргаж, гамшгийн хуулийн<br>хэрэгжилтийн хүрээнд тус оны 4 дүгээр<br>сард мэргэжлийн ангийн бэлэн байдлыг<br>хангаж, эрүүл мэндийн албан цугларч,<br>аймгийн онцгой байдлын газрын үнэлгээнд<br>хамрагдан, хангалттай үнэлгээ авсан<br>Аймгийн хэмжээнд эхний 5 сарын байдлаар<br>Ковид-19 халдварын 3 тохиолдол<br>бүртгэгдэж 10 000 хүн амд 0.3 промилль<br>байгаа нь 2023 оны мөн үеэс (1) 0.2 пр<br>нэмэгдэж, нас баралт 1 бүртгэгдсэн.<br>Тандалт хийж, 3 тохиолдлын ойрын<br>хавьтал болох 7 иргэнээс асуумж судалгаа<br>авч, арга зүйн зөвлөгөө өгч, халдварын<br>тархалтаас сэргийлж ажилласан. Тайлант<br>оны 05 сарын байдлаар тусгаарлах<br>эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа хүн<br>байхгүй. Коронавируст халдварын өвчний<br>дэгдэлтийн үед шаардлагатай 26 нэр<br>төрлийн эм бэлдмэл- 6125 ш, 43 нэр<br>төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл,<br>халдваргүйтгэлийн бодис- 274,142 мг/л, 43<br>нэр төрлийн багаж, лабораторийн урвалж<br>оношлуур, түргэвчилсэн тест, хувийн<br>хамгаалах хувцас-19369ш нийт 365,439,900<br>төгрөгийн өртөг бүхий 3 сарын нөөцийг<br>улсын төсвөөр тендер болон ерөнхий<br>гэрээгээр татан авч, бэлэн байдлыг<br>хангасан. Төлөвлөгөөний биелэлт 100<br>хувьтай байна. | 70% |
|---|--|---|----------------|--|----|--|-----|

|                       |   |  |             |  |        |   |      |
|-----------------------|---|--|-------------|--|--------|---|------|
| 5                     | 1.1.4. “Ковид-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, | 1. “Ковид-19” вирусийн халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнг тооцох   | 2021 - 2024 |  | "Бага" | Улс, аймгийн хэмжээнд Ковид-19-ын халдварын тархалт зогсож, ногоон түвшинд шилжсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн байгууллагын шийдвэрээр салбар дундын эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагагүй гэж шийдвэрлэсний дагуу эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй болно.  | 100% |
| 6                     | эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.  | 2. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжүүлэх | 2021 - 2024 |  | 95     | Эпидемиологийн 21 дүгээр долоо хоногт Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалт улсын хэмжээнд “Ногоон түвшин”-д байна. Ковид-19 халдварын тархалтын ногоон түвшинд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тушаалын дагуу томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд суурилан Коронавируст халдварын тандалтыг өргөжүүлэх, журмыг дагуу зохион байгуулж, тандалтыг молекул биологийн ПСР лабораторид хийж байна. 2024 оны эхний 5 сарын байдлаар тандалтын 307 сорьцод шинжилгээ хийснээс, 37,1 хувь эерэг бөгөөд эерэг сорьцын 58.9 хувь нь RSV, 39,6 хувь нь А(Н3N2), 1,5 хувь нь SARS-Cov-2 вирус илэрч амьсгалын замын өвчлөлийн шалтгаан болсон. | 100% |
| 2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ |   |  |             |  |        |   |      |

|   |   |   |             |  |     |  |      |
|---|---|---|-------------|--|-----|--|------|
| 7 | 2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | 1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх | 2021 - 2024 |  | 100 | 2022-2023 онуудад анхан шатны нэгж 20 сумын эрүүл мэндийн төв, Баянхонгор сумын 4 өрхийн эрүүл мэндийн төв гүйцэтгэлийн санхүүжилтээр байгууллагын 3 нэр төрлийн нийт 32 лабораторийн тоног төхөөрөмж шинэчлэгдэж, оношилгоо үйлчилгээг цаг алдалгүйгээр иргэдэд үзүүлж байна. Энэ хүрээнд анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг хангалт 100 хувьтай болсон . Тайлант оны эхний 5 сарын байдлаар нийт 9584 шинжилгээ хийгдэн нотолгоонд тулгуурласан онош тодруулж, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулсан. | 100% |
|---|---|---|-------------|--|-----|--|------|

|   |   |             |  |      |  |      |
|---|---|-------------|--|------|--|------|
| 8 | 2. Уламжлалт-сэргээн засах төвийг шинээр зохион байгуулан, шаардлагатай багаж хэрэгслээр ханган, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 3000 | Уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээг Нэгдсэн эмнэлгийн тасаг, сум, ерхийн эрүүл мэндийн төвүүд, Баянундрага зэндмэнь, Амар амгалан Шаргалжуут сувилал, хувийн хэвшлийн ортой эмнэлэг Ганзүү, клиник (Дуут баян богд, Ганууд, Наран оч, Дэр сил) эмнэлгүүд үзүүлж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар уламжлалт эмчилгээний тасагт - 358 хүн хэвтэн эмчлүүлж, өдрийн эмчилгээгээр -200 хүн эмчилж, Амбулаториор- 2100 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна. Уламжлалт, сэргээн засах эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмж, орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх зорилгоор байгууллагын төсвийн хөрөнгөөр 139,600,000 төгрөгний тендер зарлаж, уламжлалт, эмийн бус эмчилгээний болон хөдөлгөөн засал эмчилгээ нэр төрлийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Шинээр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг эмчилгээ үйлчилгээнд ашиглаж, эмчилгээний нэр төрлийг олшруулан Ультразвук эмчилгээг давхардсан тоогоор-340, цахилгаан гүйдэл эмчилгээ-УВЧ-575, искра-217, цахилгаан бумба эмчилгээ-630, лазер эмчилгээ-160, цахилгаан зүү-480, хаш чулуун ор-210, татлага эмчилгээ-85, төөнө-350, улаан туяа-91, самнуур-94 хүнд тус тус хийсэн байна. Хөдөлгөөн засалчийг | 100% |
|---|---|-------------|--|------|--|------|

|    |  |             |  |     |  |     |
|----|--|-------------|--|-----|--|-----|
| 9  | 3. Зүрх судасны эмгэгийн тасаг зохион байгуулан, зүрхний шигдээсийн үеийн эмчилгээг хийж хэвшүүлэх | 2021 - 2024 |  | 16  | Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт зүрхний шигдээсийг оношлох, эмчлэх нэгжийг зохион байгуулсан ба 2024 оны эхний 5 сарын байдлаар зүрхний шигдээс өвчнөөр 1 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн. Тайлант оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд УГТЭ-ийн зүрхний эмч нартай хамтран сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 22 эмчийг чадавхжуулах сургалтад хамруулж, МнКардио программын шинэчлэлийг танилцуулж, хэрэглээний сургалтуудыг тус тус зохион байгуулсан. Зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөл эхний 5 сарын байдлаар 10 000 хүн амд 560.6 байна. | 70% |
| 10 | 4. Уушигны дурангийн оношилгооны чиглэлээр хүний нөөцийг бэлтгэн, тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх   | 2021 - 2024 |  | 3.6 | Уушгины дурангийн оношилгооны чиглэлээр хүний нөөц бэлтгэгдсэн. 2024 оны эхний 5 сарын байдлаар 170 үйлчлүүлэгчид спирометрийн шинжилгээ хийсэн. Өөрчлөлттэй илэрсэн 19 иргэнийг эмнэлгийн хяналтад авсан. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад 2 үйлчлүүлэгчийг илгээсэн байна. Сүрьеэгийн өвчлөл 2024 оны 5 сарын байдлаар 10 000 хүн амд 1.7 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.1 хувиар өссөн бна.   | 70% |

|    |  |             |  |     |  |     |
|----|--|-------------|--|-----|--|-----|
| 11 | 5. Вирус судлалын лабораторийг шинээр нээх                                     | 2022 - 2024 |  | 20  | Нэгдсэн эмнэлгийн вирус судлалын лабораторид элэгний В,С D вирус тоолох шинжилгээг 210 хүнд, амьсгалын замын өвчин үүсгэгч илрүүлэх шинжилгээг 633 хүнд, бэлгийн замын өвчин үүсгэгч шинжилгээ-233, хүний папиллом вирус илрүүлэх шинжилгээ-200 хүнд тус тус хийж, нотолгоонд тулгуурласан оношлогоо эмчилгээний стандартыг мөрдөн ажилласан. Вирус судлалын лаборатори хэвийн үйл ажиллагаа явуулж байна. | 70% |
| 12 | 6. Элэгний В вирустай эхчүүдээс төрсөн нярай бүрт Гепабиг эмчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 |  | 200 | Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулан ажиллаж байна. 2024 оны эхний 05 сарын байдлаар элэгний В вирусийн халдвартай 28 эх төрсөн. 2024 оны 1 сараас эхлэн гепабиг тариа улсын хэмжээнд тасалдал үүсч, 5 дугаар сард нийлүүлэгдэж эхлэсэн. Түүнээс хойш 5 хүүхдэд гепабиг эмчилгээ хийгдсэн байна.   | 50% |



|    |   |   |             |  |     |   |     |
|----|---|---|-------------|--|-----|---|-----|
| 13 | 2.1.2. Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Цэргийн насны 18-25 насны эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх | 2021 - 2024 |  | 250 | Цэргийн насны эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, 2024 оны цэрэг татлагаар үзлэгт нийт 674 цэргийн насны залуучууд хамрагдсанаас 434 буюу 64,3 хувь нь өвчний учир тэнцээгүй байна. Нийт хамрагдсан иргэдээс дараах өвчлөл бүртгэгдсэн. Дотрын өвчлөл – 120, Шүдний өвчлөл – 573, Мэдрэл,сэтгэц - 93, Нүдний өвчлөл – 91, Чих хамар хоолойн өвчлөл – 162, Мэс засал, гэмтэл – 188, Арьс харшил- 116, Нийт өвчлөл давхардсан тоогоор 1343 байна. Өвчлөлийг анхан шатны эрүүл мэндийн төвүүд хяналтандаа авч, эмчлэн, цэргийн насны 398 залуу эрүүлжүүлсэн. | 70% |
| 14 |   | 2. Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх                     | 2022 - 2024 |  | 500 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүд урологийн кабинетыг зохион байгуулж, эхний 5 сарын байдлаар нийт 1200 эрэгтэйчүүдэд үзлэг оношлогоо хийсэн байна. Урологи, андрологийн эмч Б.Энхжаргал нь "Эрчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа" уриан дор "Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд" сэдэвт сургалтыг хийж, нийт 24 байгууллагын 80 гаруй эрэгтэй албан хаагч хамрагдаж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар мэдлэгээ нэмэгдүүлсэн байна.  | 70% |

|    |   |             |  |     |   |     |
|----|---|-------------|--|-----|---|-----|
| 15 | 3. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | 2022 - 2024 |  | 100 | <p>“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 8 ажил төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 64 хувьтай. Хүн амын нас хүйс эрсдэлт хүчин зүйлд тулгуурласан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт 701 эрэгтэйг хамруулсан. Баянхонгор сумын төвөөс алслагдсан нутаг дэвсгэрт амьдарч буй 30 эрэгтэйгээс сүрьеэ, чихрийн шижин, түрүү булчирхайн өвчлөл илрүүлэх асуумж судалгаа авч ажилласан. Судалгааны үр дүнд 2 хүний эмгэгийг илрүүлэн онош баталгаажуулж, эмчилгээ хийж, эмчийн хяналтанд авсан. Эрт илрүүлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр видео контент бэлтгэн, цахим орчинд байршуулснаар 11000 хандалт авсан. Цэрэг татлагын үед “Архи тамхины хор уршиг”, “БЗХӨ”, “Эрэгтэйчүүдэд зонхилон тохиолддог өвчлөл” сэдвүүдээр гарын авлага бэлтгэж 253 ширхгийг тараасан. “Бусдын татсан тамхины утаа намайг, таныг хайртай хүмүүсийг тань хордуулсаар” сэдэвт 3 минутын видео шторк, БЗДХ өвчлөл, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр 3 төрлийн зурагт хуудас, 4 төрлийн зөвлөмж бэлтгэн Эрүүл мэндийн газрын фэйсбүүк хуудас болон анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн цахим хуудаст түгээж 746 хандалт авсан.</p> | 70% |
|----|---|-------------|--|-----|---|-----|

|    |  |  |             |  |    |   |     |
|----|--|--|-------------|--|----|---|-----|
| 16 | 2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 1. Бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах | 2021 - 2024 |  | 60 | <p>Аймгийн хэмжээнд эхний 4 сарын байдлаар 490 халдварт өвчин бүртгэгдсэнээс 188 буюу 38.3 хувийг БЗДХ-т өвчин эзэлж байна. Өвчлөл 10 000 хүн амд тэмбүү 5.8 пр, Заг хүйтэн 5.8, трихомониаз 9.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 промилоор нэмэгдсэн үзүүлэлттэй. Сайн дурын зөвлөгөө шинжилгээний төвөөр эхний 5 сард нийт 448 иргэн үйлчлүүлснээс 10 тэмбүү илрүүлэн бүрэн эмчилсэн. Үйлчлүүлэгчдэд тав тухтай орчин бүрдүүлэх үүднээс орон нутгийн санхүүжилтээр хүлээлгийн буйдан, гадна хаяг, зөөврийн компьютер, хурууны хээ уншигч, сервер гэх мэт 13.0 сая төгрөгний тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. БЗДХ-ын тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулж, салбарын удирдлагууд, Өсвөр үеийн Ирээдүйн босго төв, БЗДХ-ын кабинет болон өрхийн ЭМТ –ийн төлөөлөл нийт 28 эмч, мэргэжилтэн, сумын ЭМТ-ийн дарга, эх баригч, лаборант нар цахимаар оролцон хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг 2024 оны 283 дугаар албан бичгээр нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>"Харамсахгүйн төлөө хамтдаа" аяны хүрээнд бэлтгэгдсэн 6 төрлийн видео шторк болон зөвлөмжийг аймгийн лед дэлгэцээр өдрийн 2-3 удаагийн давтамжтай 2 сарын хугацаанд тогтмол нэвтрүүлж, Номгон телевиз, Эрүүл мэндийн газар</p> | 70% |
|----|--|--|-------------|--|----|---|-----|

|    |  |             |  |   |  |     |
|----|--|-------------|--|---|--|-----|
| 17 | 2. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 |  | 3 | <p>“Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний хэрэгжилт 87.5 хувьтай байна. Тэмдэглэлт өдрийн хүрээнд зарим сумдын онцлог үйл ажиллагааг дурьдвал Бууцагаан сумын “Эрүүл мэндийн төв”, “Buutsagaaniihan bid” фэйсбүүк группүүдээр сүрьеэ өвчний талаар өдөрт 2-оос доошгүй мэдээллүүдийг түгээсэн. Зурагт хуудас – 20, видео шторк – 10 тус тус нийтэлж, хандалтын тоо 203-366 байна. Арсэдийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын дунд 03 дугаар сарын 20-27 хүртэлх хугацаанд “Тийм ээ, бид сүрьеэг устгаж чадна” сэдэвт гар зургийн уралдаан зарласан. Уралдаанд нийт 28 сурагчийн бүтээл ирүүлсэн. Аймгийн хэмжээнд цэрний сорьц тээвэрлэх тогтолцоог эрчимжүүлж, сар бүр сорьц тээвэрлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. 2024 оны эхний 5 сарын байдлаар нийт 9 сорьц тээвэрлэсэн. Сүрьеэгийн өвчлөл 5 сарын байдлаар 10 000 хүн амд 1.7 байна.</p> | 70% |
|----|--|-------------|--|---|--|-----|

|    |  |  |             |  |      |  |     |
|----|--|--|-------------|--|------|--|-----|
| 18 | 2.1.4. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Ревматологийн эмчийг бэлтгэх, бодлогоор дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах           | 2022 - 2024 |  | 200  | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт дотрын мэргэжлийн 8 их эмч, хувийн хэвшлийн эмнэлэгт 5 их эмч, анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд 12, нийт 25 эмч дотрын өвчин судлалын чиглэлээр аймгийн хэмжээнд тусламж үйлчилгээ үзүүлж байна. Нэгдсэн эмнэлэгт ревматологийн чиглэлээр 3 дугаар шатлалд ажиллаж байсан 1 эмчийг орон тоогоор авч ажиллуулж, ревматологийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч байна. Артерын гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 2024 оны эхний 5 сарын байдлаар 44815 хүн хамрагдаж, 32.6 хувьтай. Чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 26361 иргэн хамрагдаж, 35.9 хувьтай байна. | 50% |
| 19 |  | 2. Нярайн зүрхний гажигийг эрт илрүүлэх, скрининг болон сонсголын гажиг илрүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 |  | 1500 | Нярайн төрөлхийн сонсгол бууралт илрүүлэх шинжилгээ 2022 оноос эхлэн хийгдэж, нийт 3381 нярай хамрагдаж, давтах шаардлагатай 219 нярай гарч түүнээс 51 нярайг давтан үзсэн. Цаашид оношлогооны зорилгоор ЭХЭМҮТ-д 3 нярайг илгээсэн. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар нярайн зүрхний гажигийг эрт илрүүлэх скрининг шинжилгээ хийгдэж эхлээгүй байна.   | 50% |

|    |  |  |             |  |   |  |     |
|----|--|--|-------------|--|---|--|-----|
| 20 | 2.1.5. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана. | 1. Иргэдийн хүлээгдэл чирэгдэлийг багасгаж, эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх | 2021 - 2024 |  | 0 | Иргэдийн хүлээгдэл, чирэгдлийг багасгах зорилгоор Нэгдсэн эмнэлгийн амбулаторит үзүүлэх цагийг иргэд emongolia,эрүүл мэндийн цаг захиалгын утас 18000119, амбулаторийн суурин 70444039, цахим бүртгэл зэргээс авснаар өглөө эрт болон шөнө зогсож дугаар авах байдал багассан. 2024 оны 05 дугаар сараас эхлэн emongolia-оос жирэмсний хөтөч, дархлаажуулалтын мэдээлэл, эмийн жор, дүрс оношилгооны зураг, дүгнэлт зэргийг авах боломжтой болсон. Дэмжих төвийн хүлээгдэл чирэгдэл бага буюу 1-2 хоногт тухайн үйлчлүүлэгч (70 хувь) бүх тусламж үйлчилгээг авч байна.Эрүүл мэндийн салбарт 2024 оны эхний хагас жилийн байдлаар 44 өргөдөл, хүсэлт, гомдол ирсэнээс 40 өргөдлийг 100 хувь бүрэн шийдвэрлэж, хугацаа болоогүй судлагдаж байгаа 4 өргөдөл байна. | 50% |
|----|--|--|-------------|--|---|--|-----|

|    |   |  |             |  |     |   |     |
|----|---|--|-------------|--|-----|---|-----|
| 21 | 2.1.6. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Өвчтөний түүхийг цахимжуулж, E-Health программыг бүрэн нэвтрүүлэх | 2021 - 2024 |  | 100 | E-Health цахим програмын 13 модуль 600 цэсийг аймгийн Нэгдсэн эмнэлэг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэн нийт 331 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Энэ онд E-Health программд шинээр нэмсэн өндөр өртөгт болон иммунологи шинжилгээ, Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх/ясны эд/, Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх/Мэс ажилбараар авсан эд/, Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх/1 маркерийн үнэлгээ/ болон Торчийн шинжилгээнүүдийг оруулсан. Мөн Херпес (IgM), (IgG), Цитомегаловирус (IgM), (IgG), Улаанууд (Rubella IgM), (Rubella IgG) Токсоплази (Tox IgG), (Tox IgM) шинжилгээ нэвтрүүлсэн. Дүрс оношилгоонд цээжний рентген зургийг хиймэл оюун ухааны программд боловсруулж эмчилгээ үйлчилгээндээ ашиглаж байна. Шинээр цахимд Эмгэг судлалын маягтууд • Эмгэг судлалын шинжилгээний протокол Эс-1 • Эмгэг судлал микро • Эмгэг анатоми сорьц хүлээн авсан тэмдэглэл • Амьд сорьцын шинжилгээний хуудас • Умайн хүзүүний эсийн шинжилгээний хуудас • Бамбай булчирхайн эсийн шинжилгээний хуудас зэрэг маягтуудыг холбож, үйл ажиллагааг цахимжуулсан. Программ ашиглалт 90 хувьтай байна. | 90% |
|----|---|--|-------------|--|-----|---|-----|

|    |  |  |             |  |    |  |     |
|----|--|--|-------------|--|----|--|-----|
| 22 |  | 2. Олон улсын эмнэлзүйн удирдамж Upto date программыг нэвтрүүлэх | 2021 - 2024 |  | 90 | <p>Олон улсын эмнэлзүйн платформ Uptodate программыг жилийн эцсийн хяналт үнэлгээний шалгуурт оруулсан. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ажлын байран дээр очиж платформыг нээх, ашиглалтыг сайжруулах зөвлөгөө өгснөөр Нэгдсэн эмнэлгийн 82 их эмчээс 66 эмч буюу 80 хувь нь, Сум, өрхийн 70 их эмчээс 52 эмч буюу 74 хувь, Хувийн хэвшлийн 44 эмчээс 12 эмч буюу 27 хувь нь тус тус хэрэглэж байна. Нийт эмч нарын 70 хувь нь тусламж үйлчилгээнд ашиглаж байна. Анхан шатны нэгжүүдээс Богд, Эрдэнэцогт, Баянговь сумын эмч нарын ашиглалт сайн байна. Шинээр 2024 оны 05 дугаар сарын 15-16-нд Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 65 эмч, мэргэжилтэнд платформ программ суулгаж ашиглах заавар зөвлөгөөг өгснөөр аймгийн 210 эмчээс 70 хувь нь хэрэглэж байна.</p> | 90% |
|----|--|--|-------------|--|----|--|-----|



|    |  |  |             |  |      |   |     |
|----|--|--|-------------|--|------|---|-----|
| 23 | 2.1.7. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 1. Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр сургалтад хамруулах | 2021 - 2024 |  | 1000 | Эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг хөгжүүлэх цахим, танхим, ажлын байрны болон төгсөлтийн дараах дээшлүүлэх дотоод, гадаад сургалтуудад нийт 2414 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан байна. Тухайлбал: Цахим сургалт болох Умайн гаднах жирэмслэлт, их хэмжээний цус алдалт, Нярайн эндэгдлийн өнөөгийн байдал, Зүрх судасны эмгэгтэй жирэмсэн эхийн хяналт; Давтан кесар мэс заслын үед умайн агшилт сулрал болон их цус алдалтаас сэргийлэх менежмент зэрэг 20 нэр төрлийн сургалтад 670 эмнэлгийн мэргэжилтэн, Аймгийн Засаг даргын тамгын газар болон холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан ажлын байрны "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, төлөвлөлт", "Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт", Үндэсний бичгийн анхан шатны сургалтад нийт 339 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан. Танхимын сургалт болох Digital first –цахимд хэвшье, Эмч таниараа бахархая хэлэлцүүлэг, сургалт, Улаанбаатар хотод болсон Цахим эрүүл мэнд үндэсний зөвлөлдөх уулзалт, сургалт, Төрийн бүтээмжийн сэргэлт- Цахим эрүүл мэнд хангайн бүсийн нэгдсэн сургалт, "Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар | 70% |
|----|--|--|-------------|--|------|---|-----|

|    |  |                |  |    |   |     |
|----|--|----------------|--|----|---|-----|
| 24 | 2. Иргэд<br>үйлчлүүлэгчдээс<br>сэтгэл ханамжийн<br>судалгаа авч, ёс<br>зүйгээрээ бусдыгаа<br>манлайлсан<br>ажилтнуудыг<br>урамшуулах,<br>алдаршуулах | 2021 -<br>2024 |  | 93 | Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/21 дугаар тушаалаар хэрэглэгчийн үнэлгээ авах ажлын хэсэг байгуулагдаж, Нэгдсэн эмнэлэг, 20 сум, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаториор үйлчлүүлсэн 630 иргэнээс цаасан хэлбэрээр судалгаа авч, нэгтгэн үр дүнг тооцон ажилласан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан “Бид-Ёс зүйгээр манлайлна” аянд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, идэвх зүтгэл гарган ажилласан байгууллага, эмнэлгийн мэргэжилтнүүдийг батлагдсан шалгуурын дагуу шилдгүүдийг шалгаруулан урамшуулсан. Ёс зүйтэй байгууллагаар “Жаргалант сумын эрүүл мэндийн төв”, Хэрэглэгчийн үнэлгээгээр Ёс зүйтэй эмчээр Наранмандал өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ч.Өлзийжаргал, Ёс зүйтэй тусгай мэргэжилтнээр Бөмбөгөр сумын эрүүл мэндийн төвийн бага эмч С.Баатар, Ёс зүйтэй сувилагчаар Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч Б.Баасандолгор нар тус тус шалгарсан байна. Эерэг сэтгэл ханамж 96 хувьтай. | 50% |
|----|--|----------------|--|----|---|-----|

|    |  |             |  |    |   |     |
|----|--|-------------|--|----|---|-----|
| 25 | 3. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах | 2021 - 2024 |  | 92 | <p>Хүний нөөцийн стратегийн хүрээнд салбарын хэмжээнд 2013-2016 онд хэрэгжүүлсэн “Шинэ зууны эмч” аймгийн дэд хөтөлбөр, 2016-2020 онд хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн ажилтны хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд сумдын эмч нар 100 хувь эмчийн орон сууцаар хангагдсан. 2024 онд шинэ барилга байгууламж, урсгал засвар үйлчилгээнд зориулж улсын төсөвт нийт 5497.2 тэрбум төгрөг суугдсан. Үүнд: Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн өргөтгөлийн барилга 2976.4, Хүрээмарал сумын эрүүл мэндийн төвийн барилга 206.7, Наркалогийн төв эмнэлэг 2314.1 төгрөгийн төсөв батлагдсан. Орон нутгийн 2024 оны төсөвт Нэгдсэн эмнэлгийн эмгэг судлалын байрыг шинээр барих 402.0, Шинэжинст сумын эрүүл мэндийн төвийн засварт 120.0, Бөмбөгөр сумын эрүүл мэндийн төвийн гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж 20.0, Оточномгон өрхийн эрүүл мэндийн төвийг ашиглалтад оруулах 180.0, Заг сумын эрүүл мэндийн төвийн цэвэр бохир усны системд холбох ажлыг хийж гүйцэтгэхэд 70.0, Галуут сумын эрүүл мэндийн халдвартын барилгын гадна талын дулаан, цэвэр бохир усны шугам, цахилгааны ажлыг хийж гүйцэтгэхэд 20.0 нийт 812.0 төгрөгийн төсөв тус тус батлагдаж, эмнэлгийн барилга байгууламжийн ашиглалт сайжруулахаар төлөвлөгдсөн байна. Эрдэнэцогт,</p> | 90% |
|----|--|-------------|--|----|---|-----|

|    |   |  |             |  |     |   |     |
|----|---|--|-------------|--|-----|---|-----|
| 26 | 2.1.8. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэнэ. | 1. Амбулаторийн барилгыг шинээр ашиглалтад оруулах | 2021 - 2024 |  | 100 | Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтанд нийт 2.976,5 сая төгрөг батлагдаж, Нэгдсэн эмнэлгийн Амбулаторын барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна. Уг барилга ашиглалтад орсноор аймгийн 89.000 гаруй хүн амд хоёрдогч шатлалын өндөр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанар, стандартын шаардлагад нийцсэн ая тухтай орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэх юм. | 90% |
|----|---|--|-------------|--|-----|---|-----|



|    |  |   |             |  |      |   |     |
|----|--|---|-------------|--|------|---|-----|
| 29 | 2.1.9. Эм, эмнэлэгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумдын эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгоно. | 1. Антибиотикийг жороор олгосон байдалд хяналт үнэлгээг хийж, хариуцлагатай тогтолцоог бий болгох | 2021 - 2024 |  | 6000 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 24 эмийн сангаас сар бүр жорын судалгаа авч, дүгнэлт гарган шаардлагатай зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна. 2024 оны эхний 5 сарын байдлаар нийт 15 эрүүл мэндийн байгууллагаас ирсэн 2700 ширхэг жор хүлээн авсан ба үүнээс эмчийн тамгагүй жор 4 хувь, өвчтөний нас хүйс бичээгүй 2 хувь, оношны код бичээгүй 3 хувь, антибиотик эмийн жор 32 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн газрын даргын удирдамжаар Хүрээмарал, Баянбулаг, Бөмбөгөр сумдад хяналт үнэлгээ хийж, эм зүйн тусламж үйлчилгээ, эмийн талаар баримтлах стандартын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан. | 70% |
|----|--|---|-------------|--|------|---|-----|



|    |  |   |             |  |               |  |      |
|----|--|---|-------------|--|---------------|--|------|
| 31 | 2.2.1. Спорт цогцолбор бүхий усан бассейныг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | 2. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулах | 2022 - 2024 |  | 80<br><br>500 | 2024 оны эхний хагас жилд / 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/ шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор Улсын төсвөөс 491,1 сая төгрөг, Орон нутгийн төсвөөс 1,019,9 сая төгрөгийн санхүүжилтийг авч батлагдсан төсвийн хүрээнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төсвийг үр ашгийг дээшлүүлэн ажиллаж байна. Тайлан оны эхний хагас жилийн байдлаар Спорт цогцолбор бүхий усан бассейнаар үйлчлүүлсэн иргэдийн тоо 56199 байна.              | 100% |
| 32 | 2.2.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ.                                  | 1. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх     | 2022 - 2024 |  | 100           | “Эрүүл иргэн-Хонгорын баялаг 2024” ажлын байрны дасгалыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хагас жилийн байдлаар 34 сум, байгууллагын 10672 иргэн хамрагдаад байна. Мөн “Бүжгээр эрүүлжье” аяныг аймгийн төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран баганат талбайд 7 хоногийн 2 өдөр зохион байгуулж эхлээд байна. Энэ хүрээнд эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 44 биеийн тамир спортын арга хэмжээнд 45739 иргэд хамрагдаж, 9 төрлийн секц дугуйланд 415 хүүхэд хамрагдаад байна. | 90%  |



|    |   |             |  |       |   |      |
|----|---|-------------|--|-------|---|------|
| 33 | 2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах                          | 2021 - 2024 |  | 30000 | Аймгийн хэмжээнд нийт 34 спорт заал үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс сумын төвд 8, Биеийн тамир спортын газрын харъяа 9, бусад нь сургууль албан байгууллагын спорт заал байна. Биеийн тамир спорт хороотой 2024 оны эхний хагас жилийн байдлаар 34 албан байгууллага, аж ахуйн нэгж хувь хүн заал ашиглах гэрээ хийж үйл ажиллагаа тогтмол зохион байгуулж байна. Залуучууд болон ахмад настангууд хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор дээрх спорт заалуудад эхний 5 сарын байдлаар 6624 иргэн үйлчлүүлсэн байна. | 100% |
| 34 | 3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах | 2021 - 2024 |  | 1     | Сумдад 18 спорт заал хэвийн үйл ажиллагаа явуулж байгаагаас 10 сумын спорт зааланд засвар үйлчилгээ, тохижилтын ажил хийгдэж, Шинэжинст суманд спорт заал шинээр ашиглалтад орж, Бөмбөгөр сумын спорт заалны ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Мөн “Бүргэд” боксын клубыг 19,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажил хийгдэж байна.  | 90%  |

|    |   |   |             |  |     |   |      |
|----|---|---|-------------|--|-----|---|------|
| 35 | 2.3.1. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2022 - 2024 |  | 100 | <p>2021 оны эхэнд сургууль завсардах магадлалтай 84 сурагч байсныг сургуульдаа эргэн суралцах боломжоор бүрэн хангаж өгснөөр сургууль завсардалт гараагүй. Нийт 30 сургуулийн 50 хувьд орон сэтгэл зүйч ажиллаж, хоцрогдол арилгахад эцэг эх, сургуулийн зөвлөлийн үүрэг оролцоог нэмэгдүүлж цахимаар суралцах боломжийг нэмэгдүүлсэн. Сургуульд суурилсан үнэлгээнээс сурлагын амжилтыг 20 болон түүнээс илүү хувь ахиулсан 5 багшийг шалгаруулж урамшуулсан. 2022 онд 600 багшид 2023 онд дахин 600 багшид өндөр үзүүлэлттэй зөөврийн компьютерийг олгосон. БШУГ болон 6 сургуульд 21 сая төгрөгийн цахим сургалтын лаборатори, 650 сая төгрөгийн үнэтэй таблет бүхий цахим хэрэглэгдэхүүнээр 6 сургуулийг хангасан байна. Багш нар 265 цагийн контент бүтээж, 30000 гаруй тестийн сан бүрдүүлсэн Сурлагын хоцрогдол нөхөх, арилгахад 13 сургууль тус бүрд нийт 77 дэмжигч, 5 сургууль 38 явуулын, 8 дадлагын багшийг ажиллуулсан байна. Зуны сургалтанд 219 багш хамрагдсан. Дотуур байрын багшийн үйл ажиллагааг Сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгахад чиглүүлэн ажиллав. 4. ЕБС-д 101, СӨБ-д 46, насан туршийн боловсролд 52, “ХБХХөгжүүлэх төв”-д 25 нийт 224 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж</p> | 100% |
|----|---|---|-------------|--|-----|---|------|



|    |   |  |             |  |    |   |     |
|----|---|--|-------------|--|----|---|-----|
| 37 | 2.3.2. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ. | 1. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг чадваржуулах сургалтад хамруулах        | 2021 - 2024 |  | 40 | Тусгай хэрэгцээт боловсрол олгох шаардлагатай хүүхдийн нас бие бэрхшээлийн онцлогт тохирсон "Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг хэрхэн үнэлэх нь" арга зүйн сургалтыг 30 сургалтын менежерүүдэд, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах арга зүй" сэдэвт сургалтыг цахимаар 1 удаа танхимаар 3 удаа 120 багшид, тэгш хамран сургах боловсролын талаарх үндсэн ойлголтыг нэмэгдүүлэх, дэмжлэгийн багийн үйл ажиллагаанд анхаарч, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн туршлага судлах, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарыг чадваржуулах сургалтыг цахим хэлбэрээр нийт 92 багшийг хамруулан сургалт зохион байгуулж нийт 240 багшийг чадавхжуулав. | 90% |
| 38 |   | 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, орчинг сайжруулах | 2021 - 2024 |  | 2  | Өлзийт, Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургууль, Баянхонгор сумын Ерөнхий боловсролын "Номгон" сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тоног төхөөрөмжийг НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгөөр олгож ашиглаж байна.   | 90% |

|    |   |  |             |  |    |   |     |
|----|---|--|-------------|--|----|---|-----|
| 39 | 2.3.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ. | 1. "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2024 |  | 80 | Зөв зохистой хооллолт, эрхтэн тогтолцооны хөгжил алдагдахаас урьдчилан сэргийлэх, бичил тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж нийт 4987 хүнд эрүүл хооллолтын зөв дадлыг төлөвшүүлэхэд нөлөөлж ажилласан. Олон улсын Эко-сургууль /цэцэрлэгүүдэд/ зориулсан Ахисан шатны 3 дахь сургалт амжилттай хамрагдаж Баянхонгор сумын 5,10,13,16, Шинэжинст, Бууцагаан сумдын цэцэрлэгүүд амжилттай хамрагдсан."Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, аймгийн ногоон хөгжилд суурилсан хэтийн зорилт дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, ногоон хөгжил тогтвортой хөгжлийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд мэргэжил арга зүйгээр хангахад чиглэгдсэн ISO14001 стандартыг сургалтын хөтөлбөртөө тусган ажилласан. Энэ ажлын хүрээнд 7000 гаруй хүүхдэд байгаль дэлхийгээ хайрлах төлөвшлийг олгож дадал хэвшил болгоход анхаарч ажиллаж байна. "МӨНГӨН ГЭРЭГЭ" өргөмжлөлийн болзол хангасан Баянхонгор сумын 3, 6, 7, 12, Гурванбулаг сумын цэцэрлэг, "ХҮРЭЛ ГЭРЭГЭ" өргөмжлөлийн болзол хангасан Баянхонгор сумын 5, 10, 13, 16, Өлзийт, Бууцагаан, Шинэжинст сумын цэцэрлэгүүд өргөмжлөлөө хүлээн авсан. "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-хөтөлбөрийн 2024 | 90% |
| 40 |   | 2. Бага насны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн орчны сайжруулах                       | 2021 - 2024 |  | 2  | Аймгийн хэмжээний төрийн өмчийн 36 цэцэрлэг 100 хувь стандартын шаардлага хангасан гал тогтоотой үйл ажиллагааг явуулж байна. 2024 онд нийт 30 цэцэрлэгт 235,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хангалт хийгдэж сайжруулсан.  | 90% |

|    |  |             |  |     |   |      |
|----|--|-------------|--|-----|---|------|
| 41 | 3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах | 2021 - 2024 |  | 100 | Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж 5 настай 7617 хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд бэлтгэн 1-р ангид суралцуулсан. 5 настай хүүхдийн хамран сургалтын хувь 2021 онд 83- байсан бол 2024 онд 100 хувь хамруулж өссөн үзүүлэлтэй байна. 2022 оны сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 75%, 2023 оны сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 69% ба улсын дунджаас 0,7%-иар бага үнэлгээтэй байна. Үнэлгээг ахиулахын тулд сургалтын хөтөлбөртөө тохируулга хийж, хүүхдийн хөгжлийн үнэлгээг бодитой хийхэд анхаарч багш нар харилцан туршлага солилцож хүүхдийн ахиц амжилтыг үнэлэх арга барилаа дээшлүүлэн, багш бүр даалгаврын аргачлал боловсруулан нийтдээ 213 хэрэглэгдэхүүний сан бүрдүүлж ажилласан. | 100% |
|----|--|-------------|--|-----|---|------|

|    |  |  |             |  |    |   |     |
|----|--|--|-------------|--|----|---|-----|
| 42 |  | 4. Хүүхэд харах төвийн үйлчилгээг тогтворжуулж, ясли байгуулах асуудлыг судлах | 2021 - 2024 |  | 10 | 2023-2024 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 3 төв, 6 багш, 30 хүүхэдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Бууцагаан сумын 90 ортой хуучин цэцэрлэгийг шинээр засварлаж 15 хүүхэд авах яслийн ангийг нээж тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулсан. Хүүхэд харах үйлчилгээний эрх зүйн орчин тодорхойгүй , хувьсах зардал багасаж, санхүүжилт нь удаашралтай, мэргэжилийн багшлах хүний нөөц дутмаг, орчинд нөхцөл стандартын шаардлага хангахгүй зэрэг шалтгаанаар татан буугдаж байгаатай холбоотой хүүхэд харах үйл ажиллагааг явуулах төвийг нэмэх боломжгүй байна | 70% |
|----|--|--|-------------|--|----|---|-----|

|    |  |  |             |  |   |   |     |
|----|--|--|-------------|--|---|---|-----|
| 43 | 2.3.4. Сургууль, цэцэрлэгийн барилгын стандарт, норм нормативийг мөрдүүлж, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ. | 1. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах         | 2021 - 2024 |  | 1 | Тайлант оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бөмбөгөр сумын цэцэрлэгийн барилгын ажил 50 хувь, ОНХС хөрөнгөөр Өлзийт сумын сургуулийн дотуур байр, Богд сумын цэцэрлэгийн их засвар, Баянцагаан сумын сургуулийн спорт заал, Баянбулаг сумын хичээлийн хуучин байрны их засвар, Галуут сумын сургуулийн дотуур байрны хоол үйлдвэрлэлийн заалны их засвар, Баянхонгор сумын 6, 12 дугаар цэцэрлэгийн их засварын ажил хийгдэж байна. | 70% |
| 44 |  | 2. Нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 6 | Тайлант онд Богд, сумын сургууль, цэцэрлэг, Шинэжинст сумын дотуур байр, Хүрээмарал сумын сургуулийн дотуур байр, цэцэрлэг, Гурванбулаг сумын сургуулийн барилгад стандарт ариун цэврийн байгууламж шинээр болон их засварын ажлууд хийгдэж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлсэн. Нийт сургуулийн 81 хувь, дотуур байрны 77 хувь, хүүхдийн цэцэрлэгийн 95 хувь нь орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болсон байна.                                  | 70% |



|    |   |  |             |  |    |  |     |
|----|---|--|-------------|--|----|--|-----|
| 45 |   | 3. Цэцэрлэгийн гадна талбайг стандартын шаардлагын дагуу тохижуулах              | 2021 - 2024 |  | 2  | Баянхонгор сумын 11,12 дугаар цэцэрлэгийн гадаа талбайн тоглоом нийлүүлэх тендерт “Би би ди эм эм” ХХК шалгарч, 26,490,000 төгрөгний гадаа талбайн тоглоом, биеийн тамирын хэрэгсэл нийлүүлэхээр гэрээ хийгдсэн. Гэрээний дагуу гадна талбайн тоглоомыг 11 дүгээр цэцэрлэгт 12.5 сая, 12 дугаар цэцэрлэгт 13.8 сая төгрөгний төсөвт өртөгтэй тоглоомын багцыг тус тус нийлүүлсэн. Цэцэрлэгүүд гадна тохижилт хийж, тоглоомоо байршуулсан. Богд, Баян-Өндөр сумдын цэцэрлэгүүд барилгын их засвар хийснээс гадна тоглоомын талбайг тохижуулж, шинэ тоглоомын хэрэгсэлүүдийг суурилуулсан байна. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар нийт 4 цэцэрлэгт гадна тохижилт хийгдсэн байна. | 90% |
| 46 | 2.3.5. Сургуулийн дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль бүрт “Үдийн хоол” олгох боломжийг бүрдүүлнэ. | 1. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 |  | 90 | Байгууллагын төсвийн зохицуулалтаар 2021 онд Галуут сумын сургуульд 17.5 сая, Баянлиг сумын сургуульд 9.0 сая төгрөгөөр тус тус 2-р хоолны тогоо, хөргүүр, дээжийн хөргөгч, 3-н дамжилга, жигнүүр зэрэг гал тогооны тоног төхөөрөмжүүд нийлүүлсэн. 2022 онд Бууцагаан, Хүрээмарал, Соого-Сейко, Эрдэм, Номгон сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн. Нийт 31 сургуулиас 10 сургууль зориулалтын хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж дутмаг байна. Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулиудын хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хангалт 2024 оны эхний хагас жилийн байдлаар 67,7 хувьтай байна.             | 90% |

|    |  |  |             |  |     |  |     |
|----|--|--|-------------|--|-----|--|-----|
| 47 | 2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ. | 1. Тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 750 | БНОХ-ийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, 2023-2024 оны хичээлийн жилд БНОХ-өөр 537 суралцагч суралцсан ба 115 нь эмэгтэйчүүд байна. Түүнчлэн насны ангиллаар авч үзвэл: 7-10 насны 11 суралцагч, үүнээс эмэгтэй 1 11-17 насны 202 суралцагч, үүнээс эмэгтэй 25, 18-34 насны 232 суралцагч, үүнээс эмэгтэй 44, 35-аас дээш насны 92 суралцагч, үүнээс эмэгтэй 45 2. Боловсролын түвшнээр ангилбал: Бага боловсролд 24 суралцагч, үүнээс эмэгтэй 5, Суурь боловсролд 254 суралцагч, үүнээс эмэгтэй 72, Бүрэн дунд боловсролд 259, үүнээс эмэгтэй 38 3 байна. Сургалтын хэлбэрээр ангилбал: Танхимаар 225 суралцагч, үүнээс эмэгтэй 53. Танхимын бусаар 291 суралцагч, үүнээс эмэгтэй 58. Гэрээр (явуулын багш) 21, үүнээс эмэгтэй 4 4. Тэгш хамрахаар нь ангилбал: Малчин өрхийн 321 суралцагч, үүнээс эмэгтэй 72. Хийдэд шавилдаг 25 суралцагч. Хөгжлийн бэрхшээлтэй 27, үүнээс эмэгтэй 5 байна. Аймгийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд 263 суралцагч Бичиг үсгийн сургалтад хамрагдсан. Түүнээс эмэгтэй суралцагч-115. Түүнчлэн: 1. Насаар нь ангилбал: 18-аас доош насны 2 18-55 насны 247, 55-аас дээш насны 14 2. Түвшнээр нь ангилбал: Үл мэдэгч- Анхан шатны сургалтад 170 суралцагч, үүний 80 эмэгтэй, Бага мэдэгч- Дунд шатны сургалтад 64 суралцагч, үүний | 70% |
|----|--|--|-------------|--|-----|--|-----|



|    |  |                                       |             |  |   |  |      |
|----|--|---------------------------------------|-------------|--|---|--|------|
| 49 | 2.3.8. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, сургуулийн орчны нэвтрэлт бүртгэлийн системийг шинээр нэвтрүүлнэ. | 1. "Онлайн кабинет" төсөл хэрэгжүүлэх | 2021 - 2024 |  | 5 | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжийг нэмэгдүүлж, 642,0 сая төгрөгийн өртөг бүхий Дижитал ангийг Баянхонгор сумын Номгон, Эрдэнэмандал, эрдэм, Соого сейкео, Гэгээн сумади сургууль, Бууцагаан, Өлзийт, Бөмбөгөр, Жаргалант зэрэг 9 сургуульд байгууллаа. Ухаалаг самбарыг ЕБС-д нийлүүлж сургалтын орчныг бүрдүүлсэн. Цахимаар суралцах орчныг бүрдүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар боловсролын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй ерөнхий боловсролын хичээлийн байр 5, дотуур байр 22, цэцэрлэгийн 6 байрыг УТР болон шилэн кабелиар интернэтэд холбосоноор аймгийн нийт 30 сургуулийн хичээлийн байр, дотуур байр 100 хувь боловсролын нэгдсэн сүлжээнд холбогдсон. Дээрх байранд дотоод сүлжээ, утасгүй интернэтийн орчныг сайжруулж дууссан. Интернэтийн урсгалын хурдыг 10Mbps-аас 1Gbps хүртэл нэмэгдүүлсэн буюу газарзүйн байршлаас хамаарч 4-100 дахин өссөн. 78 ухаалаг самбар 149 хромбүүк, 892 зөөврийн компьютер, 25 мэдээлэл зүйн танхим, 258 таблет, 201 суурин компьютер, 85 ухаалаг телевизийг ашиглаж байна. Цахим танхимд сурагч хэрэглэх 1775 ширхэг Таблет, Хромбүүк, Whale book, Lenovo зэрэг | 100% |
|----|--|---------------------------------------|-------------|--|---|--|------|

|    |  |             |  |     |  |      |
|----|--|-------------|--|-----|--|------|
| 50 | 2. Багш нарыг компьютер, планшетаар хангах | 2021 - 2024 |  | 300 | УИХ-ын дарга Г.Занданшатар “Багш бүрд компьютер” хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор аймгийн ЕБС-ийн багш нарыг өндөр хүчин чадал бүхий зөөврийн компьютерээр хангаж төслийн хүрээнд төрийн өмчийн бүх сургууль, цэцэрлэгийн 1140 багш нарыг 100 хувь компьютероор хангасан. Энэ нь боловсролын салбарын ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлээд байна. | 100% |
|----|--|-------------|--|-----|--|------|

|    |  |  |             |  |     |   |     |
|----|--|--|-------------|--|-----|---|-----|
| 51 | 2.4.1. Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн үйл ажиллагааг сайжруулна. | 1. Сургалтын орчныг сайжруулж, боловсон хүчнийг чадавхжуулах | 2021 - 2024 |  | 200 | Аймаг орон нутагт “Менежментийн хөтөлбөр”-өөр боловсон хүчин бэлтгэхэд хамтран ажиллаж, 32 мэргэжилтэн бэлтгэгдэж, төгсөх курст суралцаж төгсөж байна. 2023-2024 оны хичээлийн жилд нийт 105 оюутан суралцаж байна. Сургалтын орчныг сайжруулах хүрээнд шинэ суурьшлын бүс 9 дүгээр багт сургуульд 29780 м.кв газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх гэрчилгээ олгож, газартай болоход дэмжлэг үзүүлсэн. Тус эзэмшил газарт ХААИС-ийн салбар сургуулийн шинэ цогцолбор баригдах бөгөөд 300 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилга барих зураг төсөв болох 200.0 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэхээр дэмжин ажиллаж байна. Хагас жилийн байдлаар зураг кадастрын түвшинд явж байна. | 70% |
|----|--|--|-------------|--|-----|---|-----|

|    |   |  |             |  |     |   |     |
|----|---|--|-------------|--|-----|---|-----|
| 52 | 2.4.2. "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, жижиг дунд үйлдэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.                                | 1. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах   | 2021 - 2024 |  | 100 | "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран хувиараа хөдөлмөр эрхлэгч 200 иргэнд зээлийн өмнөх аж ахуй эрхлэх сургалтыг зохион байгуулж, чадавхжуулсан. Сургалтын зардалд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3.0 сая төгрөг зарцуулсан. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 120 иргэнд зээлийн дараах сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулна.   | 70% |
| 53 | 2.4.3. Шинэ мэдлэг, патент гаргасан эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн судалгааг гарган бүртгэлжүүлж, урамшуулна.                            | 1. Эрдэм шинжилгээний багийг байгуулж, шинэ мэдлэг патентыг бий болгох                               | 2022 - 2024 |  | 6   | Аймгийн Засаг даргын "Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, зөвлөлийн дүрэм батлах тухай" 2023 оны А/196 захирамжаар Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг, Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн дүрмийг тус тус батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. 2023 онд Оюуны өмчийн газраас Баянхонгор аймгийн иргэн хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй 37 патент байсан бөгөөд хагас жилийн байдлаар патентын тоо нэмэгдээгүй байна. | 90% |
| 54 | 2.5.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралаа авч явах дадал, хэвшлийг дээшлүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна. | 1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажлын байр бий болгох, ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулах | 2021 - 2024 |  | 500 | Аймгийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд "Эрдэнэ Монгол" ХХК-ний Баян Хөндий төслийн хүрээнд 193 иргэнийг байнгын ажлын байраар, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор сумын шинэ хорооллын хамгаалалтын ногоон байгууламж тариалах ажилд 41 иргэнийг түр ажлын байраар, Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн зуданд зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг устгах ажилд 16 сумын 281 ажилгүй иргэнийг түр ажлын байраар, нийт 515 иргэнийг ажлын байраар хангаж ажиллалаа.                     | 70% |

|    |  |   |             |  |      |  |     |
|----|--|---|-------------|--|------|--|-----|
| 55 | 2.5.2. Өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.                  | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх        | 2021 - 2024 |  | 250  | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Хөдөлмөрт бэлтгэх сургалтын суурь ур чадвар олгох сургалтад 275 иргэнийг, Политехник коллежтой хамтарсан танхимын сургалтад /тогооч, компьютерын хэрэглээ, Барилгын сантехникч, өрөг угсрагч, барилгын мужаан, цэцэрлэгжүүлэлт/ 117 иргэнийг, нийт 392 хүнд мэргэжил олгосон. Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 56 иргэн /төсөл/ хамрагдаж 112 байнгын ажлын байраар хангасан. Арга хэмжээг зохион байгуулахад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 32.250.000 төгрөг зарцуулсан. Малчдыг малжуулах арга хэмжээнд 170 өрх, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд 12 сумын 106 ахмад, нийт 276 төслийн сонгон шалгаруулалт хийгдэж байна. | 70% |
| 56 | 2.5.3. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана. | 1. Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний ач холбогдлыг таниулж, нийгмийн баталгааг хангах | 2021 - 2024 |  | 8150 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа. Энэ оны хагас жилийн байдлаар 4993 иргэн хамрагдсанаас малчин 4153 шинээр 66 малчин нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдсан байна.   | 70% |



|    |   |  |             |  |       |   |      |
|----|---|--|-------------|--|-------|---|------|
| 57 | 2.5.4. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.                                       | 1. Хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулах                                   | 2021 - 2024 |  | 200   | Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөр эрхлэх чадвартай 124 иргэнийг нийтийг хамарсан /Баянхонгор сумын шинэ хорооллын хамгаалалтын ногоон байгууламж тариалах, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн зуданд зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг устгах / ажилд ажиллуулж түр ажлын байраар хангаж 44.6 сая төгрөг зарцуулсан.   | 70%  |
| 58 | 2.5.5. Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар хуримтлалтай болгох арга зүйд сургаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай болгон "Хуримтлалтай хүүхэд" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Хүүхэд бүрт хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгох" | 2022 - 2024 |  | 15000 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор ирээдүйн өв сангийн тухай хуульд заасны дагуу хүүхдийн мөнгөн хуримтлалыг төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журмын дагуу "Хүүхэд бүрд хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгох" зорилтыг дэвшүүлэн ажиллаж байсан боловч Уг тогтоолыг Засгийн газрын 2023 оын 01 сарын 05-ны өдрийн 11-р тогтоолоор хүчингүй болгож хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам шинэчлэгдсэн. Аймгийн хэмжээнд тус оны 05 дугаар сарын гүйцэтгэлээр 0-18 хүртэлх насны 34641 хүүхдэд 17,111,8 сая төгрөгийг олгож ажилласан байна. | 100% |

|    |   |   |             |  |    |  |      |
|----|---|---|-------------|--|----|--|------|
| 59 | 2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна. | 1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалтыг сайжруулах                                  | 2021 - 2024 |  | 6  | Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэх сурталчлах ажлын хагас жилийн биелэлт 21 сумын хэмжээнд 80 хувийн биелэлттэй байна. Сумууд соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахаар хамгаалалтын зурвас хийх, хашаа татах, улсын тусгай хамгаалалтад оруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Соёлын өвийг хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад музей үзүүлэх, түүх, соёлын үнэт зүйлийн талаар сургалт орох, аялалд явж түүхэн газруудтай танилцуулах, гарзураг болон танин мэдэхүйн уралдаан зохион байгуулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.Тайлант оны хагас жилийн байдлаар нийт 14 соёлын дурсгалыг хамгаалалтад авсан. | 70%  |
| 60 |   | 2. Иргэдийн гар дээр байгаа баримтат өвийг бүртгэх  | 2021 - 2024 |  | 60 | Соёлын баримтат өвийг бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд 5 сумын иргэдийн гар дээр хадгалагдаж буй 4 ширхэг судар, соёлын баримтат өвд хамаарах 13 ширхэг өвийг бүртгэн баримтжуулалт хийгдсэн байна.  | 90%  |
| 61 |   | 3. Биет бус өвийг хамгаалан түгээн дэлгэрүүлэх сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах | 2022 - 2024 |  | 5  | Соёлын биет бус өвийг хамгаалан түгээн дэлгэрүүлэх сургалт, уралдаан тэмцээн зэрэг 25 арга хэмжээ зохион байгуулж, Өлзийт, Баянцагаан сумдын морин хуурын дугуйлангийн сурагчдын тоглолт 2 удаа зохион байгуулж нийт 750 гаруй хүүхэд багачууд, болон насанд хүрэгчид хамрагдаж 480,000 мянган төгрөг зарцуулсан байна.  | 100% |



|    |   |   |             |  |     |  |     |
|----|---|---|-------------|--|-----|--|-----|
| 63 | 2.6.3. "Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Соёлтой Баянхонгорчууд" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | 2022 - 2024 |  | 100 | "Соёлтой Баянхонгорчууд" арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/407 дугаар тушаалаар батлуулсан. 19 сумын соёлын төвийн номын санч нарыг чадавхжуулах сургалт, ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах удирдамж боловсруулан хүргүүлж, номын санч нарыг бакалаврын боловсрол олгох эчнээ хөтөлбөрт хамруулж нийт 6 албан хаагч номын сан судлал мэргэжлээр суралцаж байна. | 50% |
|----|---|---|-------------|--|-----|--|-----|

|    |   |   |             |   |   |      |
|----|---|---|-------------|---|---|------|
| 64 | 2.6.4. Соёлын төвүүдийн орчин нөхцлийг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Соёлын төвүүдийн барилгыг шинэчлэх, иргэдийг соёлын боловсролын судалгааг хийх | 2021 - 2024 | 0 | 50<br>Соёлын сайдын 2023 оны А/390 тушаалаар батлагдсан “Үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал” тооцох журмын дагуу Соёлын байгууллагуудын 2022 оны ажлыг дүгнэж 23 соёлын байгууллагад 206558.7 мян төгрөгийн үр дүнгийн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон бөгөөд журмын дагуу үүний 40 хувь буюу 82623.5 мян төгрөгийг байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад зарцуулан үр дүнг тооцон ажилласан. 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ соёлын төвийн барилгатай болохоор Баян-Өндөр сумын соёлын төв Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд хандан хөрөнгө оруулалтыг оруулсан байна. Орон нутгийн хөгжлийн сангаас Заг сумын соёлын төв 10.0 сая төгрөгийн урсгал засвар, 30.0 сая төгрөгийн гадна тохижилт, сумын ИТХ-аас Гурванбулаг сумын соёлын төв 2.0 сая төгрөгийн засвар, Баянцагаан сумын соёлын төв 35.0 сая төгрөгөөр ариун цэврийн байгууламж, Бөмбөгөр сумын соёлын төв 10.0 сая төгрөгөөр орон нутаг судлах танхимын тохижилт, Баян-Өндөр сумын соёлын төв орон нутаг судлах танхимын тохижилт 12.5 сая төгрөг, ногоон байгууламжийн хайс 8.0 сая төгрөг, машины зогсоолын тохижилт 20.0 сая төгрөг нийт 40.5 сая төгрөгийн санхүүжилт тус тус авч үйл ажиллагаагаа өргөтгөжээ. | 100% |
|----|---|---|-------------|---|---|------|

|    |  |                |  |   |   |      |
|----|--|----------------|--|---|---|------|
| 65 | 3. Соёлын төв,<br>мэргэжлийн урлагын<br>байгууллагын тоног<br>төхөөрөмжийг<br>сайжруулах | 2021 -<br>2024 |  | 5 | 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангаас Баацагаан сумын соёлын төв 80.0 сая төгрөгөөр дэлгэц, Богд сумын соёлын төв 60.0 сая төгрөгөөр дэлгэц, Жинст сумын соёлын төв 50.0 сая төгрөгөөр дэлгэц, Баянлиг сумын соёлын төв 80.0 сая төгрөгөөр дэлгэц, Бууцагаан сумын соёлын төв 25 сая төгрөгөөр дэлгэц, Өлзийт сумын соёлын төв үзэгчийн сандал 450 ш 19.5 сая, ардын хөгжим хувцас хэрэглэл 40.0 сая, заалны хивс 12.9 сая, угсардаг тайз 31.0 сая, дэлгэц 40.0 сая нийт 143.4 сая төгрөг, Баян-Өндөр сумын соёлын төв үзэгчийн сандал 20.0 сая төгрөг шийдэж данс бүртгэлд тусгасан байна. Мөн 9 сум техник тоног төхөөрөмж, лед дэлгэцээр хангагдсан | 100% |
|----|--|----------------|--|---|---|------|

|    |   |  |             |  |         |  |     |
|----|---|--|-------------|--|---------|--|-----|
| 66 | 2.6.5. Иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, сумдын номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна. | 1. Иргэдийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 |  | 95<br>2 | Иргэдийн ном унших дадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хагас жилийн байдлаар Нийтийн номын сан болон 19 сумын соёлын төвийн номын санд хяналт шинжилгээ, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж номын сангийн нөхцөл байдалд шинжилгээ хийж соёлын төвийн номын сангийн үйл ажиллагааг жигдрүүлэх зорилготойгоор 6 чиглэлээр “Соёлын төвийн номын санчдын дунд зохион байгуулах ажил мэргэжил, ур чадварын уралдаан”-ыг зарлаж үр дүнг намрын “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийн үеэр тодруулахаар уралдааныг эхлүүлсэн. “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” хаврын номын баяр арга хэмжээг салбарын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулж 84 арга хэмжээгээр 2996 насанд хүрэгчид, 3303 хүүхэд багачууд, 30 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийт 10750 иргэдийг хамруулан ажилласан. | 90% |
|----|---|--|-------------|--|---------|--|-----|

|    |   |   |             |  |     |   |      |
|----|---|---|-------------|--|-----|---|------|
| 67 | 2.6.6. Аймгийн түүхийн музейн барилгыг барьж биет болон биет бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна. | 1. Хөдлөх дурсгалын мэдээллийн санг баяжуулах | 2021 - 2024 |  | 800 | Бууцагаан сумын орон нутаг судлах танхимд 22,0 сая төгрөгийн үнэ бүхий үзмэрийг хандиваар баяжуулж, Баацагаан сумын орон нутаг судлах танхимд 4,0 сая төгрөгийн музейн шилэн хорго хийн өгч Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл буюу музейн үзмэр 191 ширхэг үзмэрээр баяжигдсан байна. | 100% |
| 68 |   | 2. Биет бус өвийн мэдээллийн санг баяжуулах   | 2021 - 2024 |  | 11  | Соёлын биет бус өвийн мэдээллийн санг баяжуулах ажлын хүрээнд нийт 27 иргэнийг бүртгэн баримтжуулж ажилласан байна  | 90%  |



|    |   |   |             |  |      |  |      |
|----|---|---|-------------|--|------|--|------|
| 69 | 2.7.1. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ. | 1. "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа" зорилтот төсөл хэрэгжүүлэх | 2022 - 2024 |  | 6000 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажлын уялдаа холбоог нягтруулж, сургалтын үйл ажиллагааг хүртээмжтэй хүргэх, сурагч, багш, эцэг эхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг сэргээн идэвхжүүлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг дэлгэрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг үр дүнд хүргэх зорилгоор "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа" 5Х-ийн зорилтот арга хэмжээг боловсролын салбарт хэрэгжүүлэн ажилласан. Арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/307 дугаар захирамжаар "Хүүхэд хамгааллын баг" шалгаруулах болзолт уралдааныг зарлаж үнэллээ. Уралдаанд цэцэрлэгийн шилдэг багаар 1-р байр Баянхонгор сумын 15-р, 2-р байр Гурванбулаг сумын цэцэрлэг, 3-р байр Богд сумын цэцэрлэг, сургуулийн шилдэг багаар 1-р байр Богд сумын сургууль, 2-р байр Баянцагаан сумын сургууль, 3-р байр Хүрээмарал сумын сургууль тус тус шалгарлаа. Арга хэмжээг зохион байгуулахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.0 сая төгрөг зарцуулсан. Нийт 85 арга хэмжээнд 18.000 хүүхэд, залуучууд, иргэдийг хамруулсан. Зорилтот төсөл хэрэгжүүлсний үр дүнд боловсролын салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээг үр дүнтэй хүргэж, хөгжил, оролцооны арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо 15 | 100% |
|----|---|---|-------------|--|------|--|------|

|    |   |             |  |      |  |     |
|----|---|-------------|--|------|--|-----|
| 70 | 2. Эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах | 2021 - 2024 |  | 3000 | Аймгийн хэмжээнд 2024 оныг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, нээлтийн арга хэмжээг зохион байгуулан 1205 үүрэг хүлээгчид иргэдэд хүүхдийн, эрх хамгааллын талаарх ойлголт, эцэг эхийн үүрэг хариуцлагын талаарх мэдлэгийг олгосон. "Хонгорын гэр бүл" чуулганд 18 сум, 10 байгууллагын төлөөлөл 127 гэр бүлийн 254 хүн оролцож, “Гэр бүл, хүүхдийн статистик тоон мэдээлэл, анхаарах асуудал”, “Зүрх сэтгэлийн боловсрол”, “Гэр бүл ба эрүүл мэнд”, “Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эцэг эхийн үүрэг оролцоо”, “Гэр бүлийн сэтгэл зүйн дархлаа” сэдвээр сургалт хийж, ойлголт, мэдлэг өгсөн. Чуулганы төгсгөлд МУСТА С.Тогоомөнхийн зохиол “Сийлэн” драмын жүжгийг оролцогч гэр бүлүүддээ толилууллаа. Нийт 3 төрлийн 8 арга хэмжээгээр 1369 хүнд хүрч ажиллан, 9.760.000 төгрөг зарцууллаа. | 70% |
| 71 | 3. Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах            | 2021 - 2024 |  | 70   | Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг 2024 оны 11 сард зохион байгуулахаар төлөвлөсөн.Хугацаа болоогүй  | 30% |

|    |  |   |             |  |    |  |     |
|----|--|---|-------------|--|----|--|-----|
| 72 |  | 5. 4 настай хүүхэдтэй аавуудад чиглэсэн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх | 2021 - 2024 |  | 50 | Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагч залуучуудад ирээдүйн сайн аав болж төлөвших суурийг тавих зорилгоор “Сайн аав” төсөлт арга хэмжээг хэрэгжүүлж, 15 удаагийн сургалт, 3 удаагийн лекц, 9 удаагийн бүжгийн хичээлийг орсон. Хугацаат цэргийн алба хаагчдад “Гэр бүл ба эрүүл мэнд”, “Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эцэг эхийн үүрэг оролцоо”, “Гэр бүлийн сэтгэл зүйн дархлаа” сэдвээр сургалт хийлээ. Төсөлт арга хэмжээнд хамрагдсаны үр дүнд цэргийн ангийн нийт бие бүрэлдэхүүн, хугацаад цэргийн алба хаагч залуучууд хувь хүний хөгжил, хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэнд, гэр бүлийн боловсролын чиглэлээр мэдлэгтэй болсон. Арга хэмжээнд Хүүхэд хамгааллын зардлаас 1.107.500 сая төгрөг зарцуулсан. | 70% |
|----|--|---|-------------|--|----|--|-----|

|    |   |  |             |  |    |   |     |
|----|---|--|-------------|--|----|---|-----|
| 73 | 2.8.1. Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно. | 1. "Хонгорын гэр бүл" зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх. | 2021 - 2024 |  | 80 | "Хонгорын гэр бүл" арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг 2 зорилт 15 арга хэмжээтэйгээр боловсруулан, хэрэгжүүлж ажиллаж байна. Гэр бүлд зориулсан үйлчилгээг хөгжүүлж дэмжих зорилтын хүрээнд "Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга техник" сургалтад сургуулийн нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын ажилтан, сэтгэл зүйч нар нийт 90 хүнийг бэлтгэж, "Гэр бүлд зөвлөгөө өгөх" төвөөр 23 хүнд хосын болон ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр Богд суманд "Хамгаалах байр" байгуулж, тохижуулан үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Гэрлэх ёслолын үйлчилгээний журмыг аймгийн ИТХ-ын 2023 оны 16/51 тогтоолоор батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. "Сайн аав" төсөл арга хэмжээг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүн, хугацаад цэргийн алба хаагчдад хэрэгжүүлж, 15 удаагийн сургалт, 9 удаагийн бүжгийн хичээл орсон. Гэр бүлийн боловсрол олгох зорилтын хүрээнд 8 модуль сургалтыг бүх насны иргэдэд амьдралын мөчлөг, насны онцлогт нь тохирсон байдлаар үе шаттайгаар зохион байгуулж, 1008 хүн хамрагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувь. | 70% |
|----|---|--|-------------|--|----|---|-----|



|    |   |   |             |  |       |   |     |
|----|---|---|-------------|--|-------|---|-----|
| 76 | 2.8.3. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2. "Хариуцлагатай 100 залуу элч"- ийг бэлтгэх                           | 2021 - 2024 |  | 10000 | "Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал" болон амьдрах ухааны 11 модуль сургалтыг 300 хүүхэд, 312 иргэн, нийт 612 хүнд зохион байгуулсан. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих ажлын хүрээнд оюутны эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын сайн дурын сургагч бэлтгэх ажлуудыг хэрэгжүүлж, хагас жилийн байдлаар 453 оюутныг хамрууллаа.  | 70% |
| 77 | 2.8.4. Жендэр ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ.  | 2. Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 85    | Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс хамтран 2024 оны 1 дүгээр сард "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт, төсөвлөлт" сэдэвт явуулын сургалтыг Өлзийт, Баян-Овоо сумдын Засаг даргын тамгын газар, төрийн байгууллагууд, Баянхонгор аймгийн Цагдаагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газрын албан хаагчдад амжилттай зохион байгууллаа. Сургалтад нийт 212 төрийн албан хаагчдыг хамруулж, 6 модуль хичээлээр жендэрийн талаарх анхан, дунд шатны мэдлэг олголоо. 2.Жендэрийн салбар хорооны гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд 10 дугаар сард ХГБХХГ-тай хамтран сургалт зохион байгуулна.Хөтөлбөрийн хэрэгжилт 20 хувьтай байна. | 30% |

|    |   |   |             |  |      |  |     |
|----|---|---|-------------|--|------|--|-----|
| 78 | 2.8.5. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлж, сум бүрт хөдөлмөр зуслан | 1. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 1000 | Өвгөнжаргалант зуслангийн хөтөлбөрийг 2024 оны 06 дугаар сарын 09-ны өдрөөс хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Тайлант онд Ховд, Говь-Алтай аймгаас 600 хүүхэд амраахаар квот тогтоосон. Нийт 1000 орчим хүүхдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулахаар төлөвлөөд байна. | 50% |
| 79 | байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана.  | 2. Хөдөлмөр зусланг ажиллуулах  | 2021 - 2024 |  | 3    | Хөдөлмөр зуслангийн ээлжийг энэ оны 7,8 дугаар саруудад хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.   | 30% |

|    |   |             |  |    |  |     |
|----|---|-------------|--|----|--|-----|
| 80 | 3. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлэн тохижуулах | 2021 - 2024 |  | 50 | <p>Хүүхдийн авьяас чадвар, бие бялдар, ур чадварыг хөгжүүлэх, үндэсний өв соёлыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сантай гэрээ байгуулж, 25.0 сая төгрөгний санхүүжилтийг авснаар Хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, зуслангийн хөгжлийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. Үүнд: Морин хуур-10, Лимбэ-2, Шанз-2, Ёочин-2, Хуучир-2, Ятга-2, Мандолин-10, Гитар-10, Гар бөмбөг-5, Сагсан бөмбөг-5, Хөл бөмбөг-3, Теннисний ширээ-2, Волейболын тор-2, Аркет-4, Танин мэдэхүйн тоглоом-10, Монгол гэр угсардаг тоглоом-10, Номын сан байгуулах ном-180 ширхэгийг тус тус шинээр авсан. Зуслангийн 5 бүлэг, 2 гал тогоо, соёлын төв, цагдаагийн байр, теннисний өрөөний дотор болон гадна талыг будаж засварлах, зусланг тойруулан хашаа хийх, 3 газарт хаалга хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлэх зорилгоор тохижилтын ажил 70 хувьтай хийгдсэн. “Өвгөнжаргалант” хүүхдийн зусланд шинээр спорт цогцолбор, урлагийн заал, хүүхдийн нойл барьж байгуулахаар зураг төсвийг гарган, 2023 оны 12 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн санд, 2024 оны 05 дугаар сард Сангийн яаманд хүсэлтийг хүргүүлж ажилласан.</p> | 90% |
|----|---|-------------|--|----|--|-----|



|    |   |  |                    |  |    |   |     |
|----|---|--|--------------------|--|----|---|-----|
| 81 | <p>2.8.6. Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ.</p> | <p>2. Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх</p> | <p>2021 - 2024</p> |  | 10 | <p>Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллагын гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2 удаа танхимаар зохион байгуулж, 112 хүүхэд хамрагдсан. Сумдын хүүхдийн оролцооны байгууллагын гишүүдийг чадавхжуулах сургалтын цахимаар 1 удаа зохион байгуулж, 60 сурагч хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн “Эко клуб”-ын гишүүдийг чадавхжуулах сургалтыг танхимаар 1 удаа зохион байгуулж, 30 хүүхэд хамрагдсан. Аймгийн хүүхдийн зөвлөл, Лидер сурагч академи, Өсвөрийн парламент зэрэг оролцооны байгууллагуудын санаачилсан 7 ажил арга хэмжээг дэмжин хамтран ажилласан. “Даймонд майнд” академитай хамтран Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөл 30 хүүхдийг 7 хоногийн цахим сургалтанд хамруулж, “Өсвөрийн сургагч багш”-аар бэлтгэн сертификат олгосон.</p> | 90% |
|----|---|--|--------------------|--|----|---|-----|

|    |  |  |             |  |         |   |     |
|----|--|--|-------------|--|---------|---|-----|
| 82 |  | 3. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах | 2021 - 2024 |  | 40 , 90 | Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн нээлтийн арга хэмжээг сумдад зохион байгуулах ажлын хүрээнд сумдын хамтарсан багийн гишүүдэд зөвлөн туслах ажлыг санаачилан хэрэгжүүлсэн. Зөвлөн туслах арга хэмжээнд 18 хамтарсан багийн 135 гишүүн хамрагдсан. Хамтарсан багийн үнэлгээг хийж, сумдын ГХУСА33 болон сумын Засаг дарга, хамтарсан багийн ахлагч нарт үнэлгээний дүн зөвлөмжийг хүргүүлсэн. Нэгдүгээр улиралд Хамтарсан багийн ахлагч, нарийн бичгүүдийн судалгааг шинэчлэн авч мэргэжилтнүүдэд өгсөн. Хагас жилийн байдлаар хамтарсан багийн ахлагч нарт хүргүүлсэн зөвлөмжийн тоо-1, газар дээр нь зөвлөн туслах ажлыг 1-2 удаа, хамтарсан багийн кейс менежерүүдийг чадавхижуулах сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулж чадавхижуулсан. Хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн тоо 5841, насанд хүрэгчдийн тоо 8245 байна. | 70% |
|----|--|--|-------------|--|---------|---|-----|

|                                 |   |   |             |  |     |   |     |
|---------------------------------|---|---|-------------|--|-----|---|-----|
| 83                              | 2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна.                            | 1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх      | 2021 - 2024 |  | 70  | Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэх арга хэмжээний хагас жилийн биелэлт 21 сумын хэмжээнд 70 хувьтай байна. Сумууд Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн хэмжээнд ургийн бичиг хөтөлдөг өрхийн тоог гаргах судалгаа хийж, ургийн бичиг хөтлөлт, ач холбогдлын талаар сургалт зохион байгуулж ажиллаж байна. Угийн бичгийн хэрэглээг хүүхэд, залуучуудад сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Галуут сумын Засаг даргын Тамгын газар ЕБС-ийн сурагчдын дунд “Гурван үеийн намтар” угийн бичиг хөтлөх уралдаан зарлаж сурагчдын зуны амралтаар гэрийн даалгавар болгон хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа нь жишиг арга хэмжээ болж байна. | 70% |
| 84                              | 2.8.8. Сайн дурын үйл ажиллагааг дэмжин ажиллана. Сайн дурын үйл ажиллагаа эрхлэх иргэд, ААН-үүдийг хооронд нь холбох, үнэлэх системийг сайжруулна. | 1. Сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах | 2021 - 2024 |  | 100 | Сайн дурын үзэл санааг залуучуудад төлөвшүүлэх зорилготой “Нэг хамт олон - Нэг сайн дурын ажил” нөлөөллийн аяныг 2024 оны 04 дүгээр сард өрнүүлж, 30 аж ахуй нэгж, албан байгууллагын 3600 иргэн нийгэмд тустай 50 гаруй төрлийн сайн дурын ажил хийсэн. Уг арга хэмжээнд 6 аж ахуй нэгж байгууллага сайн дурын ажлыг санаачлагаараа зохион байгуулж, нийт 344 иргэн оролцсон. Зарцуулсан төсөв 6,900,000 төгрөг<br><a href="https://www.facebook.com/story.php?story_fbid=445164514847300&amp;id=100080612650564&amp;rid=Bl6g7ka22INMkC30">https://www.facebook.com/story.php?story_fbid=445164514847300&amp;id=100080612650564&amp;rid=Bl6g7ka22INMkC30</a>   | 90% |
| 3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО |   |   |             |  |     |   |     |

|    |   |  |             |  |      |   |      |
|----|---|--|-------------|--|------|---|------|
| 85 | 3.1.1. Татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган татвар төлөгчдийг бүрэн хамруулж татварын орлогын суурийг нэмэгдүүлнэ. | 1. Төрийн бусад байгууллагуудтай хамтран хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг хамруулах | 2021 - 2024 |  | 1200 | 1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Прокурорын газартай хамтран 2022-2023 онд барилга барьж ашиглалтад оруулсан аж ахуйн нэгж, иргэдийн татварын тайлан, улсын бүртгэлийн байгууллагад гаргаж өгсөн холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийж, иргэдэд төлбөрийн баримт олгуулах, судалгаа мэдээллийг тулгах ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэн ажиллаж байна. Шаардлагатай тохиолдолд татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор төлөх татвараа бууруулсан, иргэдэд төлбөрийн баримт олгоогүй, иргэн аж ахуйн нэгжүүдэд Зөрчлийн тухай хуульд зааснаар торгуулийн арга хэмжээ авахаар төлөвлөж байна. 2.Аймгийн Цагдаагийн газартай хамтран онцгой албан татварын тэмдгийн хяналт шалгалтын ажлыг "Цахим архи-худалдаа" удирдамжийн хүрээнд зохион байгуулж, Баянхонгор аймгийн 20 сумын нутаг дэвсгэрт цахимаар болон дэлгүүр, хүнсний бөөний төв, караоке, зоогийн газраар дамжуулан архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав. Хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд зөрчил бүхий архи, согтууруулах ундааг хурааж, зөрчил гаргасан 9 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 11.24 зүйлийн 1.6 дахь хэсэгт заасны дагуу | 100% |
|----|---|--|-------------|--|------|---|------|

|    |  |  |                |  |     |   |      |
|----|--|--|----------------|--|-----|---|------|
| 86 |  | 2. Газрын төлбөр<br>ногдуулалт<br>нэхэмжлэлийг 100%<br>хийж дуусгах, шугам<br>сүлжээнээс газрын<br>төлбөр авч татварт<br>хамрагдаагүй татвар<br>төлөгчдийг бүрэн<br>хамруулж бааз суурийг<br>нэмэгдүүлэх | 2021 -<br>2024 |  | 420 | Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2-т "Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан газрын жилийн төлбөрийг ногдуулж тухайн оны 02 дугаар сарын 10-ны дотор татварын албанд хүргүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай. Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу ГХБХБГ-аас газрын бүртгэл, ногдлын мэдээлэл буюу ГХБХБГ-ын Landndmen программыг татварын удирдлагын нэгдсэн системтэй холбосон ба 2024 онд 24385 нэхэмжлэхийн дугаараар 749.1 сая төгрөгийн ногдлыг цахим төлбөрийн баримтын систем болон цахим тайлангийн системээр ирүүлсэн ба Татварын газраас 229.2 сая төгрөгийн өрийг бүрэн барагдуулаад байна. 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар газрын төлбөрийн орлогоор 313.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 278.4 сая төгрөгийг аймаг, сумдын төсөвт төвлөрүүлсэн, 88.8 хувийн биелэлттэй байна. | 100% |
|----|--|--|----------------|--|-----|---|------|

|    |  |  |             |  |   |  |     |
|----|--|--|-------------|--|---|--|-----|
| 87 | 3.1.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн шалгалтыг сумдад зохион байгуулна. | 1. Эрсдэл өндөртэй төсөвт байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалт, үзлэг зохион байгуулах                            | 2021 - 2024 |  | 0 | Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 218 дугаар захирамжаар томилогдсон аймгийн Засаг даргын нэрэмжит хяналт шалгалтын ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Богд суманд Санхүү, төрийн сангийн хэлтэс, түүний харьяа агентлагуудын нийт 11 албан хаагчид очиж ажилласан. Тус ажлын хүрээнд санхүүгийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн тусалж, заавар зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажиллав. | 70% |
| 88 |  | 2. Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дүгнэлтийг байгууллага тус бүр дээр хэлэлцүүлж, залруулах арга хэмжээ авах | 2021 - 2024 |  | 0 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлсэн аймгийн засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргасан.  | 70% |

|    |   |  |             |  |     |   |      |
|----|---|--|-------------|--|-----|---|------|
| 89 | 3.1.3. Хуримтлалтай хонгорчууд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Хуримтлалын бүлгийг нэмэгдүүлэх   | 2021 - 2024 |  | 143 | Баянхонгор аймгийн Монгол банкны салбарын мэдээгээр 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдөр нийт 67769 хадгаламж эзэмшигчдийн дансанд 155,1 тэрбум төгрөгийн хадгаламж байршиж байсан бол 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн мэдээгээр нийт 67.575 хадгаламж эзэмшигчдийн дансанд 161.6 тэрбум төгрөг байршиж байгаа бөгөөд урьд оны эцсээс 4,2 хувиар буюу 6.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт 10 сумын 110 бүлэг зохион байгууллалтад орж үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж байна. | 70%  |
| 90 |   | 2. Ерөнхий боловсролын   | 2021 - 2024 |  | 6   | Хугацаа болоогүй  | 0%   |
| 91 | 3.1.4. Тунгалаг санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.         | 1. "Жишиг санхүүгийн алба" үзүүлэх сургалт" зохион байгуулах                     | 2021 - 2024 |  | 18  | Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн цахим шилжилтийн бодлого, зорилтын хүрээнд улс орон даяар 2023 оноос эхлэн төрийн сангийн нэгжүүдээр хийгдэх төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог "Төрийн сангийн удирдлагын цахим систем" буюу шинэ цахим системд бүрэн шилжүүлж "төрийн сангийн 21 нэгжүүд маань "Жишиг санхүүгийн алба" болсон.   | 100% |
| 92 |   | 2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, боловсролын | 2021 - 2024 |  | 85  | Аж ахуйн нэгж байгууллагын 2023 оны санхүүгийн тайланг ирүүлвэл зохих 1717 аж ахуйн нэгж байгууллагаас 1408 аж ахуйн нэгж байгууллага тайлан ирүүлж, тайлангийн ирц 82 хувьтай байна.   | 100% |

|    |   |   |             |  |    |   |      |
|----|---|---|-------------|--|----|---|------|
| 93 |   | 3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх       | 2021 - 2024 |  | 60 | Аймгийн хэмжээнд шинэ хоршоо байгуулагдаж байгаатай холбоотой жижиг, дунд аж ахуйн нэгж байгууллагуудад Сангийн яамны зөвшөөрөлтэй ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг ашиглахыг зөвлөж цахим системд бүртгэж байна.   | 70%  |
| 94 | 3.1.5. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулна. | 1. Төсөвт байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалт, хамгаалалттай холбоотой зөрчлийг арилгах | 2021 - 2024 |  | 0  | 2023 оны санхүүгийн тайлангаар 784 нэрийн 13,3 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Орон нутгийн өмчит эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогоор илэрсэн 90 тээврийн хэрэгсэл зөрчилтэй байснаас 52 тээврийн хэрэгслийг авто тээврийн нэгдсэн сангаас хасуулсан. Мөн маргаантай 1 тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулан балансаас балансад шилжүүлсэн. Дутагдуулсан Богд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй гинжин тракторыг хуулийн байгууллагад шилжүүлсэн бөгөөд шийдвэр гараагүй шалгагдаж байна. 2024 оны хагас жилийн байдлаар төсөвт байгууллага шинээр худалдан авсан 27 тээврийн хэрэгслийг нэр дээр шилжүүлж, улсын дугаар олгуулахаар албан бичиг Авто тээврийн төвд хүргүүлсэн. | 100% |



|    |  |             |  |    |  |      |
|----|--|-------------|--|----|--|------|
| 95 | 2. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, коджуулах | 2021 - 2024 |  | 15 | <p>Аймгийн Засаг даргын 2024 оны А/218 дугаар захирамжийн дагуу нэгдсэн шалгалтаар Богд сумын 6 төсөвт байгууллагын 9 тэрбум төгрөгийн хөрөнгийг нүд үзэн тоолж, 87,8 сая төгрөгийн хөрөнгийн зөрчил илрүүлсэний дагуу 9 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн мөрөөр 2024.05.28-ны өдөр тус сумд хяналт тавьж ажиллахад эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулах чиглэлээр 5 зөрчлийг хугацаандаа арилгасан, 1 зөрчлийг дутуу хэрэгжүүлсэн, 3 зөрчлийг арилгаагүй байна. Тус сумын 6 төсөвт байгууллага үндсэн хөрөнгийг бүрэн коджуулсан. 2.ОНӨГ-ын даргаар батлуулсан 2024.05.20ны өдрийн 01, 02 тоот, 2024.05.27-ны өдрийн 03 дугаар удирдамжийн дагуу 2024.05.21-2024.06.04-ний өдрийг хүртэл Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, Оточ номгон өрхийн эрүүл мэндийн төв, Соёл, урлагийн газарт хяналтын тооллого хийж, нийт 421,6 сая төгрөгийн хөрөнгийг тооллого хийсэн. Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн үндсэн хөрөнгийг хагас жилийн тооллогоор бүрэн коджуулж ажиллах хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Мөн тухайн байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн</p> | 100% |
|----|--|-------------|--|----|--|------|

|    |   |  |             |  |    |  |      |
|----|---|--|-------------|--|----|--|------|
| 96 | 3.2.1. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхижүүлж оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.             | 1. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх санал хүргүүлэх, уулзалт зохион байгуулах | 2021 - 2024 |  | 1  | Аймаг орон нутгаас Гадаад харилцааны яамтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр 21 төслийн саналыг хүргүүлсэн. Гадаад харилцааны яамны зүгээх НҮБ-д бидний саналыг хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна. Баянхонгор аймагт Хүүхдийг ивээх сан Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Хүүхдийг Ивээх Сан болон орон нутгийн зорилтод өрхийн эрүүл мэндийн төв, цэцэрлэг хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, харилцан хүлээх эрх, үүргээ тодорхойллоо. Тус төсөл нь бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, тэдний хэрэгцээнд нийцсэн цогц дэмжлэгийг үзүүлэх зорилготой. | 100% |
| 97 | 3.3.1. Орон нутагт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдтэй байгуулах гэрээнд төр, иргэдийн оролцоог хангаж ажиллана. | 1. Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн гэрээний хэрэгжилтийг хангуулах  | 2021 - 2024 |  | 75 | "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх" тухай гэрээг "Ай Эн Ди" ХХК-тай шинээр байгуулсан. Мөн "Эрдэнэ Монгол" ХХК, "Наранмандал Энтерпрайзес" ХХК-тай байгуулсан гэрээ хүчин төгөлдөр үргэлжилж байна. Өмнөх онд байгуулсан гэрээнүүдээс "Топ ган дриллинг" ХХК, "Монголболгаргео" ХХК, "Эрдэнэ Монгол" ХХК-ний гэрээний хэрэгжилтийг 96 хувьтай дүгнэсэн.  | 100% |

|    |  |   |             |  |    |   |      |
|----|--|---|-------------|--|----|---|------|
| 98 | 3.3.2.<br>"Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс" сургалтыг уул уурхай бүхий сумдын иргэдэд зохион байгуулна. | 1. Уул уурхай бүхий сумдын иргэдэд сургалт зохион байгуулах | 2021 - 2024 |  | 11 | "Хариуцлагатай уул уурхай" сургалтыг уул уурхай бүхий Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Галуут сумдын иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтаар "Эрдэс баялгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ба төрөөс баримталж буй бодлого", "Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт", "Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс 2021-2022 онд төвлөрсөн хандив дэмжлэг", "Хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч буй арга хэмжээ", "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам", "Уул уурхай дахь байгаль орчны салбарын бодлого" зэрэг нийт 6 сэдвээр сумын 200 гаруй иргэдэд мэдлэг олгож аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн. Энэ оны 03 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан уул уурхай бүхий Шинэжинст, Баян-Өндөр сумын 200 гаруй иргэдтэй уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | 100% |
|----|--|---|-------------|--|----|---|------|

|    |   |  |             |  |    |  |      |
|----|---|--|-------------|--|----|--|------|
| 99 | 3.3.3. “Баялагийн сан” байгуулж, олон нийтийн хяналтан дор байгаль хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн шинжтэй төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ. | 1. Баялагийн сан байгуулж, төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх | 2021 - 2024 |  | 20 | "Баянхонгор сан"-г байгуулж, сан бүрдүүлэх захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 8/07 дугаар тогтоолоор баталсан. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн яам руу хүргүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтөөр уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний дагуух хандив дэмжлэг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрөхөөр хуульчилсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 11,714.7 сая төгрөгийн 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 100% |
|----|---|--|-------------|--|----|--|------|

|     |  |   |             |  |    |   |     |
|-----|--|---|-------------|--|----|---|-----|
| 100 | 3.3.4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | 1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах. | 2021 - 2024 |  | 25 | "Хариуцлагатай уул уурхай" сургалтыг Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Галуут сумдын иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад сумдын удирдлага бичил уурхай эрхлэгч нөхөрлөлийн гишүүд, иргэд хамрагдсан ба сургалтаар Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, Төрийн хяналт шалгалт, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Байгаль орчин гэсэн 4 төрлийн мэдлэгийг олгосон. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 2021 онд 43, 2022 онд 17, 2023 онд 12 болон буурсан эерэг үзүүлэлттэй байна. | 50% |
|-----|--|---|-------------|--|----|---|-----|

|     |  |   |             |  |    |  |     |
|-----|--|---|-------------|--|----|--|-----|
| 101 | 3.3.5. Эвдэрсэн газрын тооллого судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | 1. Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах | 2021 - 2024 |  | 20 | Эвдэрсэн газрын 2021 оны тооллогоор аймгийн хэмжээнд нийт 13 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 21 багийн 120 нэгж талбарт 586,74 га талбай эвдрэлд орсон байсан. Аймгийн Засаг даргын 2023 оны “Эвдэрсэн газрын хяналтын тооллого зохион байгуулах тухай” А/317 дугаар захирамжийн дагуу хяналтын тооллогыг 2023 оны 06 дугаар сарын 10-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 17 сумын 224 нэгж талбарт 729,4 га эвдрэлд орсон байна. Үүнээс 2021-2022 онд 174,4 га, 2023 онд 43,98 га талбайд нийт 218,38 га талбайд нөхөн сэргээлтийг хийсэн буюу нийт эвдэрч орхигдсон талбайн 30 хувьд нь техникийн нөхөн сэргээлтийг хийсэн үр дүнтэй байна. | 70% |
|-----|--|---|-------------|--|----|--|-----|

|     |  |  |             |  |  |     |
|-----|--|--|-------------|--|--|-----|
| 102 | 3.4.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборыг бий болгоно. | 1. Хөдөө аж ахуйн кластерийн хүрээнд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулах | 2021 - 2024 |  | <p>Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах төслийг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэхээр дараах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулахаар ажиллаж байна. Ингэний сүүгээр нэмүү өртөг шингэсэн, гадаад зах зээлд худалдан борлуулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн үйлдвэрийн барилгын ажлыг 2021 онд тендер сонгон шалгаруулалт зарлан "Базарь дарь" ХХК шалгаран барьж 2022 онд үйлдвэрийн барилгыг хүлээлгэн өгсөн. Тоног төхөөрөмжийг БНХАУ-аас татан авч угсралтын ажил 80%-тай явагдаж байна. Тус үйлдвэрийн үйл ажиллагааг "Ингэн Эрдэнэ" ОНӨААТҮГазар байгуулагдан хариуцан ажиллаж байна. Тус төслийн нийт төсөв 3,8 тэрбум бөгөөд санхүүжилтийг бүрэн олгосон. Мах ногооны зoorь, бойны газар барих төслийн нийт төсөвт өртөг 3 тэрбум төгрөг бөгөөд тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Сант-Өндөр" ХХК шалгарч барилгын ажлыг 2021 онд эхлүүлсэн ба 2024 оны 1 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p> | 70% |
|-----|--|--|-------------|--|--|-----|

|     |  |   |             |  |   |  |     |
|-----|--|---|-------------|--|---|--|-----|
| 103 | 3.4.2. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ. | 1. Хөдөө аж ахуйн загвар хоршоо байгуулах | 2022 - 2024 |  | 1 | <p>Хоршоог дэмжих хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 90 дүгээр тогтоолоор “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III” дэд хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөр нь 2020-2024 он хүртэл хэрэгжих юм. Хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт 97.04 хувь байна. Хоршоотой холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, түгээх, сурталчлах талаар аймгийн хоршоологчдын зөвлөгөөнийг ХХААХҮЯ, Монголын ХАА-н хоршоологчдын үндэсний холбоотой хамтран 2023 оны 1 сард зохион байгуулж орн нутгийн удирдлага, хоршоодын 120 гаруй төлөөлөлтэйгээр зохион байгуулсан. Мөн "Хоршоодын шинэчлэл-хөгжлийн шинэ эхлэл" хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөн Дундговь аймаг, Гурвансайхан сумд 7 сард зохион байгуулагдсан бөгөөд тус аймгаас 4 хоршооны 8 төлөөллийг оролцуулж туршлага судлуулсан. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 13 сум 53 иргэн, хоршоодод 1.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, ажлын байр нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн.</p> | 70% |
|-----|--|---|-------------|--|---|--|-----|



|     |  |   |             |  |    |   |     |
|-----|--|---|-------------|--|----|---|-----|
| 104 | 3.5.1. “Бизнес инкубатор”-ийн бодлогыг эрчимжүүлж, гарааны бизнесийг дэмжиж бойжуулна. | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, бойжуулах | 2022 - 2024 |  | 30 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2023 онд тус аймгаас журмын дагуу шаардлага хангасан 10 ААН 1.153 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 34 ажлын байр шинээр бий болгосон. Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 2017 оноос хойш төсөв батлуулан дэмжиж ажиллаж байгаа бөгөөд энэ онд 47 иргэн, ААН-д 652.0 сая төгрөгийн зээл олгож, 73 ажлын байрыг бий болгов. Зээлийн нийт эргэн төлөлт, хүүгийн эргэлт тус санд 2 тэрбум байна. Орон нутагт хэрэгжиж буй олон улсын BEST хөтөлбөрөөс 4 иргэн, ААН-д 34.4 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгож хамтарч ажиллаж байна. Сумдад хэрэгжиж буй “Хоршоог хөгжүүлэх сан”-аас 13 сумын 47 иргэн, ААН 1.1 тэрбум төгрөгийн зээл авч, хуучин 49 ажлын байрыг хадгалж, шинээр 40 ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. | 70% |
|-----|--|---|-------------|--|----|---|-----|

|     |   |  |             |  |     |   |     |
|-----|---|--|-------------|--|-----|---|-----|
| 105 | 3.5.2. Хүн амын хүнсний хэрэгцээний нөөцийн махыг хувийн хэвшлүүдээр бэлдүүлж дэмжлэг олгоно. | 1. Махны нөөцийг бүрдүүлж, үнийг тогтворжуулах | 2021 - 2024 |  | 200 | Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ны Мах март махны үйлдвэртэй 180тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгж нь Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр болон гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалсан. Явцын хяналтыг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамжийн дагуу хийж байна. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8500, үхэр /1кг/ 10500 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй нөхцөлийг ханган ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштайгаар 2023 оны 04 дүгээр сарын 04-өөс 06 дугаар сарын сарын 04 хүртэл худалдаалсан. Гэрээний гүйцэтгэлээр нийт санхүүжилт 80.0 сая төгрөгийг "Баянхонгор констракшн" ХХК-д олгосон. | 70% |
|-----|---|--|-------------|--|-----|---|-----|

|     |   |  |             |  |    |   |      |
|-----|---|--|-------------|--|----|---|------|
| 106 | 3.6.1. Мал сүргийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимийн түвшинг нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ. | 1. Малын шилэн сонголтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 80 | Манай аймаг хонин сүргийг Баянбулаг хониор, ямаан сүргийг Бөмбөгөрийн улаан омог, Залаажинст-Эдрэн үүлдрээр сайжруулах, Тэмээн сүргийг Ламын гэгээний улаан тэмээ үржлийн хэсгээр, адуу, үхрийг өөр дотор нь сонгон үржүүлэх бодлого барьж ажиллаж байна. Сүргийн бүтцэд хонин сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор монгол оронд дасан зохицсон баталгаажсан Баяд үүлдрийн 100 толгой 2-3 настай эм хонь худалдан авч цөм сүргийн нэгжийг Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын харьяанд бий болгосон. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын санаачилгаар хэрэгжүүлж байгаа Малыг чанар сайжруулах ” Шинэ хөдөө” төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянбулаг омгийн өсвөр хээлтүүлэгч-500, хээлтэгч-400, Сэлэнгэ үүлдрийн Бухан бяруу-20 үржлийн хээлтэгч -43, Сарлагийн бухан бяруу-6 хонь, үхрийн ашиг шим, чанарт анхаарч цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор үржлийн малыг худалдан авч сумдад хүлээлгэн өгсөн.Улсын төсвийн 8,5 сая төгрөгийн хөрөнгөөр Баянхонгор, Баянговь, Баян-Овоо, Бууцагаан, Бөмбөгөр, Галуут, Гурванбулаг, Жаргалант, Заг, Эрдэнэцогт зэрэг 10 сумын 5667 бог малд, мөн Баянбулаг, Баян-Өндөр, Богд, Жинст, Өлзийт, Хүрээмарал, Шинэжинст зэрэг 7 сумын 5521 бог малын хээлтүүлэгчийн | 100% |
|-----|---|--|-------------|--|----|---|------|

|     |   |             |  |    |  |     |
|-----|---|-------------|--|----|--|-----|
| 107 | 2. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын хяналтад ялган төвлөрүүлэх | 2021 - 2024 |  | 80 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр 10262 толгой малыг, улсын төсвийн 8,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11188 толгой хээлтүүлэгчийн ангилалтын ажлыг зохион байгуулсан. Мөн Шинэ хөдөө төслийн хүрээнд баталгаажсан үүлдэр, омгийн бог малын хээлтүүлэгч худалдан авах ажлыг зохион байгуулж 20 сумын 57 багийн 62 суурьт Баянбулаг омгийн өсвөр хуц 5766 толгой, Залаажинст-Эдрэн үүлдрийн өсвөр ухна 8171 толгойг ялган төвлөрүүлсэн. | 70% |
|-----|---|-------------|--|----|--|-----|

|     |  |             |  |     |   |      |
|-----|--|-------------|--|-----|---|------|
| 108 | 3. Малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | 2022 - 2024 |  | 100 | <p>НҮБ-тай хамтран нийт 13 сумын 390 малчин өрхөд ядарч доройтсон малыг хэрхэн тэнхрүүлэх, бэлчээрийг хэрхэн зүй зохистой ашиглах, малыг хэрхэн тэжээх зэрэг сэдвээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн улс, аймгийн хэмжээнд анх удаа 20 сумын 105 багийн мянган малчныг нэг дор цуглуулж "Эрдэнэт сүргийн эзэд-1000" малчдын чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулж урлаг, спортын төрлөөр нөхөрсөг тэмцээн амжилттай зохион байгууллаа. Чуулганы үеэр урлагийн 11 төрөл, спортын 7 төрлөөр урлаг, спортын наадмыг амжилттай зохион байгуулж, оролцогчдын ур чадвар, оролцооны байдал, сахилга хариуцлагыг харгалзан өнөөдөр дүнг нэгтэн шилдгүүдийг тодрууллаа. Шилдгийн шилдэг сумаар Баянлиг сум шалгарч 20,0 сая₮, хоёрдугаар байранд Бууцагаан сум шалгарч - 15,0 сая₮, гуравдугаар байранд Бөмбөгөр сум шалгарч – 10,0 сая₮, дөрөвдүгээр байранд Баянговь сум шалгарч – 5,0 сая₮, тавдугаар байранд Хүрээмарал сум шалгарч – 5,0 сая₮-ийг тус тус гардан авлаа. Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хуралтай хамтарч "Төлөөлөгчийн нэг өдөр" арга хэмжээний үеэр 20 сумын 10,000 гаруй малчдад цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг амжилттай зохион байгууллаа.</p> | 100% |
|-----|--|-------------|--|-----|---|------|

|     |   |  |             |  |   |   |      |
|-----|---|--|-------------|--|---|---|------|
| 109 | 3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл бүс статусаа бататгана. | 1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах | 2021 - 2024 |  | 2 | 2023 онд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын А/202 тоот захирамжийн хүрээнд хэрэгжүүлж орон нутагт зонхилон гардаг мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 13 нэр төрлийн дархлаажуулалтанд 1,6 сая толгой мал хамруулах төлөвлөгөөтэйгээс 98,2 хувийн гүйцэтгэлтэй байна. Дээрхи арга хэмжээг оновчтой төлөвлөн хэрэгжүүлснээр мал амьтны халдварт өвчний гаралт өмнөх оныхоос 53 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчнөөр тайван бүсээ хадгалан ажиллаж байна. Шүлхий өвчний хавар, намрын дархлаажуулалтад 20 сумын 105 багийн 211129 мэдрэмтгий мал, амьтанг нэгдсэн системд төлөвлөж 6337 өрхийн Үхэр- 237751, гахай-171 нийт-237922 толгой мал, амьтанг хамруулан 100% гүйцэтгэлээ. Аймгийн хэмжээнд 17 сумын 92 багийн түвшинд 29656 /Тэмээ-26, Адуу- 1690, Үхэр- 5287, Хонь-10025, Ямаа-12628 /мал, амьтан зүй бусаар хорогдсон байна. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх малын сэг, зэм устгалын ажлыг зохион байгуулан ажлын хэсэгт 92 автомашин 1143 хүн хүч ажиллаж нийт-25334 /Тэмээ-17, Адуу- 1246, Үхэр-4704, Хонь-8676, Ямаа- 10395, Амьтан-296/ мал, амьтны сэг зэм устгалын арга хэмжээг зохион байгууллаа. Сэг зэмийн орчимд | 100% |
|-----|---|--|-------------|--|---|---|------|

|     |   |             |  |      |   |      |
|-----|---|-------------|--|------|---|------|
| 110 | 2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих | 2021 - 2024 |  | 8000 | Мал эмнэлгийн нэгдсэн системийн хүний нөөцийн удирдлагын системд 51-н Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, Мал эмнэлгийн газрын 43-н алба хаагч, 1 махны үйлдвэрүүдийг холбож үйл ажиллагааг системээр хянан баталгаажуулж байна. Тайлант онд нийт 8811-н удаагийн гэрчилгээ, гарал үүсэл бичигдсэн байна. Задалбал амьтан хэрэгцээлэх зориулалтаар 2364, бүтээгдэхүүнээр 5607, отор нүүдэл 326, үржилийн зориулалтаар 514-н гэрчилгээ тус тус бичигдсэн. Адууны мах 604, тэмээний мах 157, хонины мах 2009, ямааны мах 1669, үхрийн мах 2201-н гэрчилгээ тус тус зах зээлд нийлүүлэгдсэн байна. | 100% |
|-----|---|-------------|--|------|---|------|

|     |  |   |             |  |    |  |      |
|-----|--|---|-------------|--|----|--|------|
| 111 |  | 3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх | 2021 - 2024 |  | 20 | Аймгийн хэмжээнд халдвар хамгааллын иж бүрэн хувцас 800 ширхэг, нүдний шил 800ш, маск 800ш, хормогч 800ш, улавч 800ш, халдваргүйтгэлийн бодис болох Нi-сор 600кг, Нан-сон 250кг, гипохлорт кальци 200кг, супер килл 20кг, спирт76 градус 10л, спирт 96 градус 80л тус тус байна. Сумдын мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, Мал эмнэлгийн тасгууд дор бүрнээ нөөцөө бүрдүүлсэн байна. Аймгийн мал эмнэлгийн газарт халдвартгүйтгэлийн дук авто машин 2 ширхэг байна.  | 100% |
| 112 | 3.6.3. Бэлчээр менежментийг сайжруулах зорилгоор шаардлагатай цэгүүдэд уст цэг шинээр гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулна. | 1. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийх                                  | 2021 - 2024 |  | 5  | Улсын төсвийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг, Баян-Овоо, Баян-Өндөр, Богд, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баацагаан, Богд, Гурванбулаг, Өлзийт сумын нутагт гүн өрмийн худаг шинээр гаргах буюу сэргээн засварласан. Нийт 8 худаг ашиглалтад орж 12,0 мянган га бэлчээр усжуулагдаж, 16,0 мянган мал усаар хангагдлаа. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Богд сум 5 цэгт, Шинэжинст сум 2 цэгт нийт 7 цэгт ус цэгийн хайгуул хийгдсэн байна. | 70%  |
| 113 |  | 2. Аймгийн хэмжээнд дэвшилтэт аргаар бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх                                 | 2021 - 2024 |  | 20 | Улсын төсвийн 188.0 сая төгрөгөөр 18 сумын 43.3 мян га талбайд хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Аймаг, сумын орон нутгийн төсвийн 93 сая төгрөгийн хөрөнгөөр 4,9 мянган га талбайд хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулсан. Дээрх хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг 92.3 хувийн үр дүнтэйгээр Улсын байцаагчийн дүгнэлт гарсан.   | 100% |



|     |  |  |             |  |          |  |      |
|-----|--|--|-------------|--|----------|--|------|
| 114 | 3.6.4. Аймаг, сумдын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг зохих түвшинд бэлтгэнэ.   | 1. Аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг зохих түвшинд бэлтгэх   | 2021 - 2024 |  | 200 , 50 | Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолоор бэлтгэж сум бүр 30 тн өвс, 30 тн тэжээл, аймаг 200 тн өвс, 100 тн тэжээл бэлтгэхээс сумын нөөцөнд 825.4 тн өвс, 43.2 тн ногоон тэжээл, 420.9 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэсэн. Аймагт 500 тн өвс, 36,6 тн хивэг нөөцөлсөн.   | 100% |
| 115 | 3.6.5. Техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг өсгөнө. | 2. Тариалалтад ашиглах техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, дундын үйлчилгээний нэгж байгуулах | 2022 - 2024 |  | 100      | Аймгийн хэмжээнд газар тариаланд ашиглагдаж буй техникийн судалгааг жил бүр шинэчлэн хийж байна. Хүнс хөдөө аж ахуйн газар, Баянхонгор Политехникийн коллеж, Өлзийт ХААМСҮТ, сум дундын ойн анги болон Баянөсөх агро ОНӨАТҮГ-ийн техникууд тариаланчдад түрээсээр үйлчилхэд зуучлан холбож өгснөөр хаврын тариалалт, хөрс боловсруулалт, хагалгаа, төмс үрэлгээний ажлыг механикаар гүйцэтгэсэн. Энэ онд шинээр 1. Сум дундын ойн анги 130 морины хүчин чадалтай 2 трактор хадлангийн иж бүрэн 1 тоног төхөөрөмж 2. Баянөсөхагро ОНӨАТҮГ 130 морины хүчтэй 2 трактор хүнсний ногооны иж бүрдэл 1, үр тарианы үрлэгч 1 3. Баянхонгор Политехникийн коллеж 110 морины хүчтэй 1 трактор 4. Жимсний плантацийн төвд 50 морины хүчтэй 1 трактор, 3 агергат 5. ХХААГазар шинэ хөдөө төслийн хүрээнд 2 ширхэг төмс хураагч дүүжин машин тус тус шинээр авч ашиглаж байна. | 100% |

|     |  |   |             |  |        |  |      |
|-----|--|---|-------------|--|--------|--|------|
| 116 |  | 3. Хүнсний нарийн ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өвөл, зуны хүлэмжийн парк аж ахуй бий болгох | 2021 - 2024 |  | 25 , 0 | <p>Хүлэмжийн нэгдсэн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж "Нарлаг хүлэмж" ХХК-тай хамтран ажилласны үр дүнд 2 аж ахуйн нэгж, 13 иргэн нийт 18.0 сая төгрөгийн 15 хүлэмжийг өөрсдийн хөрөнгөөр худалдан авч ашигласан. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 60 ширхэг 6*10 хэмжээтэй зуны нийлэг хальсан хүлэмж, ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтаар 6*10 хэмжээтэй 21, 4*8 хэмжээтэй 21 нийт 42 ширхэг хүлэмжийг нийлүүлэн 100 хүлэмжийн агропаркийг байгуулах ажил амжилттай хэрэгжсэн. Нийт 6060 м,кв талбайд 50 иргэн тариалалт хийж 2.7 тн ургац хураан авсан үр дүнтэй байна. Улсын төсвийн санхүүжилтээр 4000 мкв талбай бүхий 7, ЖДҮ-ийн сангаас 560 м.кв талбай бүхий 4, Хятадын хамтын ажиллагааны хүрээнд 1000 м/кв 2, иргэн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр 525 м/кв 3 нийт 6000 м/кв талбай бүхий 16 ширхэг 3 улирлын нарлаг хүлэмж барьж байгуулах ажил хийгдэж байна. Үүнээс энэ онд 2525 м/кв талбай бүхий 5 хүлэмж нь ашиглалтад орж тариалалтын туршилтаа эхлүүлэх боломжтой болсон байна.</p> | 100% |
|-----|--|---|-------------|--|--------|--|------|

|     |   |  |             |  |          |   |      |
|-----|---|--|-------------|--|----------|---|------|
| 117 | 3.7.1. Гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 1. Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах | 2021 - 2024 |  | 5 , 7000 | Монгол Улсын Засгийн газраас 2023,2024,2025 оныг "Монголд зочлох жил" болгон Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Баянхонгор аймагт 2023 онд дараах томоохон ажлын хийж хэрэгжүүлээ. Үүнд: 1. "Тэмээ тэнгэрийн амьтан" тэмээний баяр, "Түйн голын жавар-2023" өвлийн наадмыг тус тус зохион байгуулж нийт 5000 гаруй дотоодын аялагч оролцсон. 2. Зочлох үйлчилгээний салбарын тогооч нарын "Өнгүүр буурч 2023" ур чадварын тэмцээнийг Баянхонгор хотод 2023 оны 05 дугаар сарын 12-13 ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. 3. Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй зочлох үйлчилгээний салбарын удирдлага, менежер, үйлчилгээний ажилчдыг чадавхжуулах сургалтыг 2023 оны 06 сарын 05, 06-нд зохион байгууллаа. 4. Монгол улсын хэмжээнд Олон улсын аялал жуулчлалын арга хэмжээ болох "Монгол туургатны харвуул их наадам"-ыг Заг-Байдрагийн хүрэн бэлчирт 07 дугаар сарын 19, 20, 21-нд амжилттай зохин байгуулж, ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО, 21 аймгаас оролцохоор ирсэн харваачид, тухайн орон нутгийн малчид, төлөөлөгчид, , ЖДҮ эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд зэрэг нийт давхардсан тоогоор 7000 орчим хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчид 120.0 гаруй сая төгрөгийг орлого олсон. 5. Мөн тусгай | 100% |
|-----|---|--|-------------|--|----------|---|------|

|     |  |  |             |  |   |   |      |
|-----|--|--|-------------|--|---|---|------|
| 118 |  | 3. Төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын тохижилтийг үе шаттайгаар хийж гүйцэтгэх | 2021 - 2024 |  | 1 | Төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг тохижуулах ажлын хүрээнд 2021 онд Цагаан агуй, Бичигт хад, Галуут сумын Өргөөтийн рашаанд тохижилтын ажил хийгдсэн ба 2022 онд Их Богдын Байгалийн цогцолборт газрын Төрийн тахилгат Их Богд уулын Цонж хайрханыг түшиглэн аялал жуулчлалын отоглох цэг байгуулсан. Энэ онд Азийн хөгжлийн банк, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн байгаль орчин болон байгалийн нөөцийн салбарт дасан зохицох чадавхыг бэхжүүлэх" төслөөс зохион байгуулсан бичил төсөл сонгон шалгаруулах уралдаанд Их богд хайрхны тохижилт болон Хүрэн бэлчир орчмыг тохижуулах төслөөр оролцон шалгарч, тохижилтын ажлыг эхлүүлээд байна. | 100% |
|-----|--|--|-------------|--|---|---|------|

|     |   |   |             |  |   |  |      |
|-----|---|---|-------------|--|---|--|------|
| 119 | 3.8.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор томоохон голуудад төмөр бетонон гүүр барина.  | 1. Томоохон голуудад төмөр бетонон гүүр барих   | 2021 - 2024 |  | 2 | 2021 онд Галуут сумын Мандалын голын 62 у/м төмөр бетон гүүрийн ажлыг “Эвт уул” ХХК, Галуут сумын Өлзийт голын төмөр бетон гүүрийн ажлыг “Их богд зам” ХХК тус тус гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан. 2024 оны хагас жилийн байдлаар Богд сумын Түйн гол дээгүүр төмөр бетон гүүр барих ажлын төндөр сонгон шалгаруулалтыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас зарлаж "Их богд зам" ХХК шалгарсан бөгөөд ажил эхлэх шатандаа явж байна. | 100% |
| 120 | 3.8.4. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэнэ. | 1. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэх | 2021 - 2024 |  | 2 | 2024 оны хагас жилийн байдлаар Баянхонгор аймгийн Нисэх буудлын аэродромын зорчих хэсгийн 21800м2 талбайг засварлах ажил дээр гүйцэтгэгч сонгон шалгаруулах төндэрийг зарлаж "Их богд зам" ХХК шалгарсан бөгөөд аэродромын нөхөөсний ажил 60%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.  | 100% |

|     |   |   |             |  |     |  |      |
|-----|---|---|-------------|--|-----|--|------|
| 121 | 3.9.1. Төвлөрсөн хот сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг сайжруулна. | 1. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станц барьж, ашиглалтад оруулах | 2021 - 2024 |  | 80  | БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 10 аймгийн төвд дулааны станц, шугам сүлжээ барих төслийг 148,0 сая долларын зээлээр хэрэгжүүлэх болсон. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын "Бьюксан Инженеринг" ХХК, туслан гүйцэтгэгчээр "МЭЗ" ХХК гэрээ байгуулж ажлыг 2022 онд эхлүүлсэн. Энэ онд дулааны станцын барилгын үндэсэн хийцлэл, нүүрс буулгах талбайн суурийн ажлууд тус тус хийгдэж дууссан. Ажлын явц 50%-тай үргэлжилж байна. Тус ажил нь 2024 оны 09 дүгээр сард ашиглалтад орно. | 100% |
| 122 |   | 2. Баянхонгор аймгийн төвийн 2 дугаар хэлхээний инженерийн шугам сүлжээг шинэчлэх | 2023 - 2024 |  | 100 | Баянхонгор аймгийн 2 дугаар хэлхээний гадна цахилгаан хангамжийн ажлыг 2024 оны улсын төсөвт тусгуулан батлуулсан. Тус ажлын тендер зарласан.  | 100% |
| 123 |   | 4. Залуус хороололд инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх               | 2022 - 2024 |  | 50  | Залуус амины орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ болон Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний (2, 3, 4, 5, 6, 7, 9-р баг)-ийн ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг "Б софт" ХХК 2022 онд ажлыг эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд Залуус хороололд дулаан цэвэр, бохир усны шугам ажлууд 2024 он хийгдэж ашиглалтад орно.  | 100% |

|     |  |   |             |  |   |  |      |
|-----|--|---|-------------|--|---|--|------|
| 124 | 3.9.2. Зарим сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2. Сумын төвүүдийг цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх | 2021 - 2024 |  | 1 | Нийт 4 суманд Сумын төвийн шинэчлэлийн ажил хийгдэж Сумын төвүүдийг цэвэрлэх байгууламжтай болгох ажлын хүрээнд Эрдэнэцогт сум, Галуут сумд цэвэрлэх байгууламж суурилуулах ажил төлөвлөгдсөн. Үүнээс Эрдэнэцогт сум "Сумын төвийн шинэчлэл"-ийн ажлын хүрээнд 60-70 м3 хүчин чадалтай "Эколос" цэвэрлэх байгууламжийг суурилуулсан. Галуут сумын "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөрийн гүйцэтгэгчээр "Алегротовер констракшн" ХХК шалгаран түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан. Энэ онд авто зам, дугуйн зам, явган хүний зам, дулааны шугамын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2024 онд цэвэрлэх байгууламжийг суурилуулна. Тус ажлын хүрээнд захиалагчийн техникийн хяналтыг 13 удаа хийж, улаан дэвтэрт үүрэг, даалгавар өгч ажилласан. | 100% |
|-----|--|---|-------------|--|---|--|------|

|     |   |  |             |  |    |   |      |
|-----|---|--|-------------|--|----|---|------|
| 125 | 3.9.3. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 1. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 40 | Ус хангамжийн эх үүсвэрт шинээр гүний худаг гаргах ажлыг Засаг даргын нөөц хөрөнгө болон НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр "Баянзаг Дриллинг" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлын бүсийн 9000 метр HDPE маркын хоолойн угсралтын ажил, 500м3 усан сангийн байгуулалтын барилгын болон шугам сүлжээ, тоноглолын угсралт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Шинэ суурьшлын бүсийн шугам хоолой тоног төхөөрөмжийг "Базардарь" ХХК нийлүүлж, шугам хоолойн угсралтын ажлыг "Чандмань-Баянхонгор" ХК гүйцэтгэн тус тус ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлын бүсэд 128м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулж 640 хүүхдийн сургуулийн 100 айлын 2 нийтийн орон сууцны барилга байгууламжийг тус тус холбосон. | 100% |
|-----|---|--|-------------|--|----|---|------|



|     |  |   |             |  |    |  |      |
|-----|--|---|-------------|--|----|--|------|
| 126 | 3.9.4. Үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.                   | 1. Баянхонгор сумын үерийн далан суваг, борооны болон хөрсний зайлуулах хоолой хийх | 2021 - 2024 |  | 40 | Баянхонгор хотын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төслийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. Тус ажил нь 2024 оны улсын төсөвт тусгагдаагүй болно.  | 100% |
| 127 | 3.9.5. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөж, оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | 1. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх              | 2021 - 2024 |  | 1  | Баянхонгор сумын Номгон 1-р багийн 10-р байрыг буулган шинээр 125 айлын орон сууц барихаар барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Зүүн шанд" ХХК, "РМБ" ХХК тус тус шалгаран барилга угсралтын ажлыг 2022 онд эхлүүлэн 2023 оны 07 сард ашиглалтад оруулсан. Рашаант 10-р багийн 1-р байрны дахин төлөвлөлтийн ажлын гүйцэтгэгчээр "Би ай эм би" ХХК шалгарсан бөгөөд Аймгийн Засаг дарга, оршин суугчид, гүйцэтгэгч 3 талт гэрээ байгуулсан бөгөөд 2023 оны 2 сард улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан. Мөн Рашаант 10-р багт 2,7,9 дүгээр байрны дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлсэн. 7 давхар 4 блок орон сууцны хотхоны барилга угсралтын гүйцэтгэгчээр "Хаш гоёо" ХХК ажиллаж 1-р ээлжийн 2 блок 98 айлын орон сууцны барилгыг 2023 оны 8 сард ашиглалтад оруулсан. 2-р ээлжийн 2 блок 80 айлын орон сууцны барилгын гүйцэтгэл 95%-тай байна. | 100% |

|     |  |   |             |  |     |   |      |
|-----|--|---|-------------|--|-----|---|------|
| 128 | 3.9.6. Аймаг, сумдын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд 1000-аас доошгүй айл өрхийг орон сууцаар хангана. | 2. Хонгор-1000 орон сууцны хороолол байгуулах   | 2022 - 2024 |  | 3   | Хонгор-1000 орон сууцны хороололд 17 байршил дээр нийтийн орон сууцны зориулалтаар газар олголт хийгдсэн. Мөн Баянхонгор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хонгор 1000 орон сууцны хорооллын талбайг өргөжүүлэн Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлд өөрчлөлт оруулсан тухай АИТХурлын 2022 оны 8/12 Тоот тогтоолоор нийтийн орон сууцны газруудыг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт эзэмшүүлсэн бөгөөд 2022,2023 онуудад төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна. | 100% |
| 129 |  | 3. Хувийн хөрөнгө оруулалтаар аймаг болон сумдад нийтийн орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах | 2021 - 2024 |  | 250 | Хувийн хөрөнгө оруулалтаар энэ онд 680 айлын 15 нийтийн орон сууцны барилга ашиглалтад оруулаад байна.  | 100% |

|                              |  |   |             |  |       |  |      |
|------------------------------|--|---|-------------|--|-------|--|------|
| 130                          | 3.9.7. Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг нэмэгдүүлж, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станцыг шинэчилнэ. | 1. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийх   | 2022 - 2024 |  | 100   | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 110/35/10кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг "ДМТМ" ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд 110кВ-ын ХХБ-ийн барилгын ажил, 16 МВТ-ын трансформатор секц 1-ийг 10 кВ руу шилжүүлж ажил, 5 МВАр SVG-1 тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил, 10кВ-ын тулгуур солих, трансформаторын хайрга солих, 10кВ-ын гаргалгааны кабелийн ажил, 110 кВ-ын Т-1 трансформаторын саармаг цэг дээр NGP-110 маркийн саармаг цэгийн салгуур шинээр суурилуулах, 110 кВ-ын Т-1 талын LCWB6, 50/5 гүйдлийн трансформаторыг LB7-110/W3, 150/5 гүйдлийн трансформатороор солих ажлууд тус тус хийгдээд байна. Тус ажил нь 2024 оны 3 дугаар улиралд ашиглалтад оруулна. | 100% |
| 131                          | 3.9.9. Аймгийн суурьшлын бүсүүдийг хамарсан утасгүй сүлжээний дэд бүтэц байгуулна.                                       | 1. Утасгүй сүлжээний орчинг бий болгож, төрийн цахим үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлэх | 2022 - 2024 |  | 4 , 0 | 2019 оноос хэрэгжүүлж буй "Ухаалаг цамхаг" төслийг нийт 270 сая төгрөгөөр Баянхонгор сумын 2,3,7,9-р багийн нутаг дэвсгэрт утасгүй сүлжээний орчин бий болгохоор ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага хүлээлгэж өгөөгүй байгаа бөгөөд хуулийн байгууллагад шилжүүлсэн.  | 90%  |
| 4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО |  |   |             |  |       |  |      |

|     |  |                                |             |  |    |  |     |
|-----|--|--------------------------------|-------------|--|----|--|-----|
| 132 | 4.1.1. "Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2022 - 2024 |  | 40 | Төрийн албаны сонгон шалгаруулалт, ажлын байрны сул орон тооны судалгаа, мэдээлэлд үндэслэн 2023-2026 онд хэрэгжүүлэх "Төрийн мэргэшсэн албан хаагч" хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна. Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, мөн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн чадавхжуулах, ажлын байранд нь мэргэшүүлэх төлөвлөлтийг байгууллагын төсөвтэй уялдуулан хийж, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийн хүрээнд аймгийн 181 төрийн байгууллагын 83 нь буюу 45,8 хувь нь байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээний хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг боловсруулж төсөв санхүүжилт, нөөцийг тодорхойлж нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж ажиллахаар 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд санал оруулаад байна. | 90% |
|-----|--|--------------------------------|-------------|--|----|--|-----|

|     |  |   |             |  |     |   |      |
|-----|--|---|-------------|--|-----|---|------|
| 133 | 4.2.1. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна. | 1. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сахилга хариуцлагыг чангатгах | 2021 - 2024 |  | 130 | <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 14 дүгээр удирдамжийн дагуу Хууль сурталчлах хянан шалгах, зөвлөн туслах ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 25-наас 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд Баянхонгор аймгийн 5 суманд амжилттай зохион байгуулсан. Сургалтад Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж сурталчлах, Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ойлголт хандлагыг бий болгох, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах сургалтыг сумдын Төрийн албан хаагчид, иргэд болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулан ажилласан. Сургалтад иргэд 303, төрийн албан хаагч 290, сурагч-123, нийт 716 хүн хамрагдсан байна. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын шинэчлэлийн дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх аяныг байгууллагууд зохион байгуулж журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна. Мөн төрийн албаны "ХНУМТ" цахим системд мэдээллийг үнэн зөв оруулах, мэдээллийн шинэчлэх асуудлыг сум байгууллагын дарга, удирдлагуудад чиглэл</p> | 100% |
|-----|--|---|-------------|--|-----|---|------|

|     |   |  |             |  |     |  |     |
|-----|---|--|-------------|--|-----|--|-----|
| 134 | 4.3.1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох. | 1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа авах | 2021 - 2024 |  | 100 | Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хангалт, мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдын мэргэшүүлэх судалгаанд 40 агентлаг, байгууллагын 265 албан хаагчийн хамруулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. Энэхүү судалгаанаас харахад төрийн байгууллагад ажиллах мэргэжлийн хүний нөөц дутмаг, тэр тусмаа сумд ажиллах мэдээллийн технологийн мэргэжилтэн байхгүй байгаа нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа сумдад доголддог байна. Улсын хэмжээнд Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академаас зохион байгуулж байгаа Төрийн албан хаагчдын цахим ур чадварын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаанд 1124 албан хаагчийг идэвхтэй хамруулав. Тус судалгааны нэгдсэн дүнг И-Монгол академи танилцуулна. Судалгааны линк: <a href="https://forms.office.com/r/TrveuCXa3d">https://forms.office.com/r/TrveuCXa3d</a> ЦХХХяамнаас 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Цахимд хэвшье" арга хэмжээний үеэр зохион байгуулсан мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт, арга хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 45 албан хаагчийг хамруулж мэдээлэл зөвлөгөө өгөн цахим ур чадвар олгох сургалтыг зохион байгууллаа. | 70% |
|-----|---|--|-------------|--|-----|--|-----|

|     |  |   |             |  |    |   |      |
|-----|--|---|-------------|--|----|---|------|
| 135 |  | 2. Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах | 2022 - 2024 |  | 80 | Аймгийн төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан ажилтнуудыг 2020 оноос хойш "ДИЖИТАЛ БАЯНХОНГОР" арга хэмжээний хүрээнд тогтмол чадавхжуулан ажиллаж байна. 2023 онд аймаг сумдын 80 гаруй байгууллагын ИТ нарт , SUPER ADMIN ( <a href="http://empasoft.mn:5000/trainingView/2/content">http://empasoft.mn:5000/trainingView/2/content</a> ), Цахим хөгжлийн багц хуулиуд, Цахим жишиг аймаг хөтөлбөр хэрэгжүүлэх аргазүйн зөвлөгөө, Цахим ур чадвар олгох сургалт (I,II,III багц) сургалтуудад бүрэн хамруулж нэгдсэн зохион байгуулалтаар ханган ажилласан бол энэ оны хагас жилийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 45 мэдээллийн технологи хариуцсан албан хаагчийг сургалтад хамруулан мэдээлэл зөвлөгөө өгч, тэдний цахим ур чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгууллаа. | 100% |
|-----|--|---|-------------|--|----|---|------|

|     |  |   |             |  |             |   |     |
|-----|--|---|-------------|--|-------------|---|-----|
| 136 | 4.3.2. E-Mongolia хөтөлбөрийн хүрээнд “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг сайжруулна. | 1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 150<br>2500 | Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлж буй цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор "ХУРДАН" цэгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байр, Баруун бүсийн худалдааны төв, Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн байр зэрэг газруудад 3 цэг шинээр байгуулан ажиллаж байна. Тус цэгүүдээр дамжуулан 2024 оны эхний хагас жилийн байдлаар 8300 гаруй төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажилласан байна. Мөн ХУРДАН цэгийг Өлзийт, Баян-овоо, Баянговь, Эрдэнэцогт, Бууцагаан, Гурванбулаг, Шинэжинст, Галуут нийт 8 сумдад нээн, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. | 70% |
|-----|--|---|-------------|--|-------------|---|-----|



|     |   |   |             |  |          |   |      |
|-----|---|---|-------------|--|----------|---|------|
| 137 | 4.3.3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх, бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ. | 1. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, тоон бичиг үсгийн ур чадварыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах | 2022 - 2024 |  | 60       | Салбарын үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, тоон бичиг үсгийн ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас "DIJITAL FIRST D1" арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр аймагт зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 600 гаруй иргэд, төрийн албан хаагчдыг хамруулж, тэдэнд цахим ур чадварыг нэмэгдүүлэх мэдлэг олгож, цахимд туршилт хийлгэж дадлагажуулсан. Мөн 19 суманд цахим ур чадвар олгох сургалтыг 2024 оны 1 дүгээр улиралд зохион байгуулж, 2700 гаруй иргэнийг хамруулан ажилласан. | 100% |
| 138 |   | 2. Бүх төрлийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулах   | 2022 - 2024 |  | 90<br>70 | Баянхонгор аймаг нь 2021 оноос тусгай зөвшөөрлүүдийн олголтыг цахимжуулж эхэлсэн бөгөөд одоогоор 21 төрлийн тусгай зөвшөөрлийг цахимаар олгож байна. Энэ оны 1 дүгээр улиралд 6 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлж, 3 дугаар улиралд багтаан 93 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимд шилжүүлэхээр "ИМОНГОЛ УТҮГ"- тай хамтран ажиллаж байна.  | 100% |
| 139 |   | 3. "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлтийг хийх   | 2022 - 2024 |  | 100      | "Цахим аймаг" бодлогын хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудын цахим хяналт, мэдээллийн нэгдсэн ДАШБОАРД-ад хөгжүүлэлт хийж, өдөр тутмын мэдээлийг нийтлэн ажиллаж байна. Иргэдийн санал, гомдол хүлээн авах <a href="http://igen.bayanhongor.gov.mn">igen.bayanhongor.gov.mn</a> цахим системийг 20.0 сая төгрөгөөр "Анарсистемс" ххк хийж дууссан бөгөөд ашиглалтад 100 хувь орсон.  | 90%  |

|     |  |  |             |  |      |  |      |
|-----|--|--|-------------|--|------|--|------|
| 140 | 4.3.4. Бүс нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Виртуал аялал хийх боломжтой "VR-Bayankhongor" төвийг байгуулж, контентийг нэмэгдүүлэх  | 2022 - 2024 |  | 700  | 2024 онд аялал жуулчлалын ""Баянхонгор аяллын хөтөч"" гар утасны апп-ыг нэвтрүүлэх бөгөөд 2023 онд зураг, ажлын даалгавар боловсруулагдаж дууссан байна. Мөн Баянхонгор сумд ""Виртуал Баянхонгор"" төвийг байгуулж тус төв нь VR технологи ашиглаж Баянхонгор аймгийн үзэсгэлэнт 7 газраар аялал хийх зориулалт бүхий төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Баянхонгор аймгийн Аймгийн ОНӨГ-с энэхүү төвийг хувийн хэвшилд төсөл сонгон шалгаруулах замаар хувьчлах үйл ажиллагаа явуулж ""Айети Юнипикэшн"" ХХК-ний төсөл шалгарч гэрээ байгуулсан. ""Баянхонгор аялал жуулчлал"" facebook хуудсаар аймгийн хэмжээний аялал жуулчлалын мэдээллийг нээлттэй мэдээлж байна. Хагас жилийн байдлаар ямар нэгэн ажил хийгдээгүй байна. | 30%  |
| 141 | 4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.       | 1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын төвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах | 2021 - 2024 |  | 1049 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/49 дүгээр захирамжаар батлуулан хэрэгжилт 60 хувьтай байна. Энэ онд аймгийн хэмжээнд шинээр авлигын гэмт хэрэг 13 бүртгэгдсэн байна. Цахим хуудасны ил тод байдал 90 хувьтай. Шударга байдлын 2023 оны үнэлгээ 75.2 хувь болж өмнөх оноос 3 хувиар өссөн байна.   | 100% |

|     |   |  |             |  |            |  |     |
|-----|---|--|-------------|--|------------|--|-----|
| 142 | 4.4.1. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна. | 1. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулах | 2021 - 2024 |  | 123 , 1720 | Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, архинд донтох эмгэгтэй 58 иргэд үзлэг хийж, 34 иргэнийг 5 ээлжээр хүлээн авч, архины сайн дурын эмчилгээнд хамруулсан. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 323 иргэдэд сургалт зохион байгуулж, орон гэргүй тэнэмэл амьдралтай, архины хамаарал бүхий иргэдийг бүртгэлжүүлэх чиглэлээр “Тэнэмэл” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 16 иргэнийг бүтгэлжүүлэн, архидан согтуурч, удаа дараа зөрчилд холбогдсон 1 этгээдийг архины албадан эмчилгээнд хамруулсан. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ГХУСАЗСЗ-өөс 1.0 сая/төг-ийг шийдвэрүүлж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 350 гаруй аж ахуйн нэгжид цахимаар болон танхимаар 3 удаагийн сургалт зохион байгуулж ажилласан. Согтууруулах ундаагаар үйлчлэх үүрэг бүхий ажилтнуудын хариуцлагатай үйлчилгээний сургалтад 2 аж ахуйн нэгжийн 8 ажилтныг хамруулсан. Согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сунгуулах 51 аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж, тусгай зөвшөөрлийн материалыг e-business.mn цахим хаягаар хүлээн авч, шийдвэрлэн | 70% |
|-----|---|--|-------------|--|------------|--|-----|

|     |  |             |  |          |  |     |
|-----|--|-------------|--|----------|--|-----|
| 143 | 2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах | 2021 - 2024 |  | 40 , 152 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг бууруулах чиглэлээр 7 нэгдсэн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 850 гаруй иргэнийг хамруулж, Авто радио 96.3-тай хамтран Гэр бүлийн хүчирхийллээс, урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ярилцлага, мэдээллийг өгч ажиллав. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 14 бүртгэгдэж өмнөх онтой харьцуулахад ижил түвшинд байна. | 70% |
| 144 | 3. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоог бууруулах                     | 2021 - 2024 |  | 20       | Аймгийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/195 дугаар захирамжаар баталж, орон нутгийн төсвөөс 2.0 сая/төг-ийн санхүүжилтийг шийдвэрлэж, нэгдсэн арга хэмжээ 5, хэсэгчилсэн арга хэмжээг 7 удаа зохион байгуулж ажилласан. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 27 бүртгэгдэж өмнөх мөн үеэс 18 нэгжээр нэмэгдсэн байна.   | 70% |
| 145 | 4. Мал хулгайлах гэмт хэргийн тоог бууруулах   | 2021 - 2024 |  | 62       | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн санаачилга, малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр 15 сумын 2000 гаруй иргэдэд сургалт зохион байгуулж, 5 төрлийн 5000 гаруй гарын авлага түгээн ажилласан. Мал хулгайлах гэмт хэрэг 8 бүртгэгдэж өмнөх мөн үеэс 11 нэгжээр буурсан байна. Мал хулгайлах гэмт хэрэг 8 бүртгэгдэж өмнөх мөн үеэс 11 нэгжээр буурсан байна.   | 70% |

|     |  |             |  |      |  |     |
|-----|--|-------------|--|------|--|-----|
| 146 | 5. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх                     | 2021 - 2024 |  | 58,1 | Эрүүжлүүлэх, саатуулах, баривчлах байрны орчин, нөхцөлийг сайжруулах, стандартад нийцүүлэх чиглэлээр 2023-2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 295.0 сая/төг-ийг шийдвэрлэж, гүйцэтгэгчээр “Буян-Арвижих-Од” ХХК шалгарч, өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж байна. Гурванбулаг, Жаргалант, сумын цагдаагийн хэсгийн байранд урсгал засварын ажлын гүйцэтгэгчээр “Буянт зэндмэнэ өргөө” ХХК, Эрдэнэцогт сумын кобаны засварын ажил гэрээ байгуулан, гүйцэтгэл 50 хувьтай байна.  | 70% |
| 147 | 7. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | 2021 - 2024 |  | 50   | 2021 онд Баянхонгор аймгийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг танилцуулсан "Аймгийн хөгжлийн зөвлөгөөн"-д Баянхонгор сумын Хяналтын камерын ухаалаг системийн төслийн дагуу 2022 онд Баянхонгор сумд 190.0 сая, Бөмбөгөр сумд 40 сая, Галуут сумд 40 сая, Жинст сумд 40 сая төгрөгийн өртөг бүхий хяналтын камерын системийн ажил хийгдсэн. Тус ажлуудаар Баянхонгор аймгийн хэмжээнд 63 ширхэг өдөр шөнө өнгөтөөр харах камер, 19 ширхэг хөдөлгөөнт камер, 4 ширхэг дугаар илрүүлэгчтэй камер суурилуулагдсан. “Мэдээлэл шуурхай удирдлагын төв”-ийг байгуулахаар орон нутгийн төсвөөс 200.0 сая /төг-ийг батлуулан, тендер сонгон шалгаруулалтыг зарласан. | 70% |

|     |  |   |             |  |      |   |      |
|-----|--|---|-------------|--|------|---|------|
| 148 | 4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлнэ. | 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 1800 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг 2024 онд дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/47 дугаар захирамжаар 3 зорилт 15 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилт 70 хувьтай. Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 15 сум, 51 байгууллагын 4700 гаруй иргэд, албан хаагч, оюутан сурагчдад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус захиалгат сургалтыг зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд Хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг 550 гаруй иргэд, төрийн албан хаагчдад өгч, 15 хууль тогтоомжоор 30 гаруй төрлийн постер бэлтгэж орон нутгийн телевиз, аймгийн <a href="http://www.bayanhongor.gov.mn">www.bayanhongor.gov.mn</a> цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар тогтмол сурталчлан, иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллалаа. Мөн шинэчлэн найруулга хийгдэх 1 хууль, 10 журмын төсөлд санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан. Иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 50 удаагийн 27 сургалтыг зохион байгуулж 4703 хүнд эрх зүйн мэдлэг олгосон. | 100% |
|-----|--|---|-------------|--|------|---|------|

|     |   |   |             |  |    |  |      |
|-----|---|---|-------------|--|----|--|------|
| 149 | 4.6.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна. | 1. Төрийн архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээнд тоон гарын үсгийг бүрэн нэвтрүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах. | 2021 - 2024 |  | 80 | "Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл"-ийг 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн архивын үйлчилгээний төв нь 29 байгууллага, 539 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч, хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсний болон бусад 561 багц лавлагаа, 4004 дугаар бүхий 2205 хуудас хуулбар хийж ажилласнаас 134 лавлагааг бусад аймаг хотоос онлайн хэлбэрээр хүлээн авч, тоон гарын үсгээр шийдвэрлэж, энэ үйл ажиллагаанд нийт цахим 8921 хадгаламжийн нэгж ашигласан нь урьд оны мөн үеэс 10.5 хувийн өсөлттэй байна. Тоон гарын үсэг олголтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, аймгийн хэмжээнд нийт 62956 иргэнд буюу 95.3 хувьд олгосон. | 100% |
|-----|---|---|-------------|--|----|--|------|

|                                 |   |             |  |      |   |      |
|---------------------------------|---|-------------|--|------|---|------|
| 150                             | 3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх. | 2021 - 2024 |  | 89   | “Цахим архив–Баянхонгор” хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх, төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/33 дугаар захирамжаар батлуулж ажилласнаар, Төрийн архив нь 15 хөмрөгийн 570 хадгаламжийн нэгжийн 24296 хуудас баримтыг цахим системд бүрэн шилжүүлж, 118882 өгөгдөл, Сан үүсгэгч 145 байгууллагын архив, албан хэрэг хөтлөгч ажилтнууд нь үндсэн 2021, нэмэлт 2007-2020 онуудын 8126 хадгаламжийн нэгжийн 130284 хуудас баримтыг цахим санд шилжүүлж, дуудалтад бэлтгэн, цаасан баримтыг ашиглалтаас чөлөөлж ажилласан нь өмнөх жилүүдийн мөн үеэс 2.8 хувиар өссөн байна. Цахимжуулалт өмнөх жилүүдийн мөн үеэс 2.8 хувиар өссөн байна. | 100% |
| 151                             | 4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг сэлбэн засах.                       | 2021 - 2024 |  | 1,29 | Архивын нэн үнэт ангиллын насжилт өндөртэй, муудаж, урагдсан цаастай 8 хадгаламжийн нэгжийн 415 хуудас баримтад цахим, нөөц хувь бий болгож, ашиглалтаас чөлөөлж, сэлбэн засах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Тайлант онд 8 хадгаламжийн нэгжийн 415 хуудас баримтад цахим, нөөц хувь бий болгож, ашиглалтаас чөлөөлж, сэлбэн засах ажлыг зохион байгуулсан.   | 100% |
| 5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО |   |             |  |      |   |      |



|     |  |   |             |  |          |  |     |
|-----|--|---|-------------|--|----------|--|-----|
| 152 | 5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ. | 2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая мод тарих | 2021 - 2024 |  | 50000,50 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10731 иргэн, 1253 айл өрх 17 төрлийн 14373 ширхэг мод, 333 аж ахуйн нэгж, байгууллага 15949 ширхэг мод, жимсний палантац 3 га талбайд байгуулж 2100 ширхэг жимсний суулгац тарьж, Цэцэрлэгт хүрээлэнд 12,8 га талбайд 12170 ширхэг мод, нийтийн эзэмшлийн талбайд 18,4 га талбайд 23233 ширхэг мод, хамгаалалтын ойн зурвас 46,3 га талбайд 39666 ширхэг мод, ойжуулалт 22,7 га талбайд 7195 ширхэг мод, Мод үржүүлгийн газрууд 187623 ширхэг тарьц суулгацыг мөчир болон үрээр тарьж ургуулж байна. Аймгийн хэмжээнд 2023 онд суулгацаар 114,686 ширхэг, үрээр болон мөчрөөр 187,623 ширхэг нийт 302,309 ширхэг модыг тарьж, бойжуулж байна. Нийт модны ургалт 76%-тай байна. | 70% |
|-----|--|---|-------------|--|----------|--|-----|

|     |  |             |  |    |  |     |
|-----|--|-------------|--|----|--|-----|
| 153 | 3. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 |  | 30 | Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг 2022 онд ШУТИС-ийн харьяа Ой модны сургалт, судалгааны хүрээлэн боловсруулсан. Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын захиалгаар "Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага" ТББ нь 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс 08 дугаар сарын 06-ны хооронд Ойн санд хөнөөлт шавжийн голомт тархалтыг тогтоох судалгааг 7 сумын нутаг дэвсгэрийн 230200 га талбайд хийлгэхэд 29700 га талбайд тархалттай, 6544 га талбайд голомт илэрсэн бөгөөд 2024 оноос эхлэн 7000 га талбайд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн Заган ойн сэргэн ургалтыг дэмжих ажлын хүрээнд Баян-Өндөр, Шинэжинст, Баацагаан сумдын нутаг дэвсгэрт 2020 оноос хойш 50 га талбай хашиж хамгаалсан, ирэх онд тус төсөлтэй хамтран заг бүхий 1000 га талбайг хашиж хамгаалахаар төлөвлөсөн. | 70% |
|-----|--|-------------|--|----|--|-----|

|     |  |   |             |  |    |  |      |
|-----|--|---|-------------|--|----|--|------|
| 154 |  | 4. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх | 2021 - 2024 |  | 35 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 08-ны өдрийн хооронд "Баян бороо-1,2" дугаар экспедиц нийт 3 удаа зохион байгуулсан. Эхний цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаагаар 8 сумын нутагт 0.0-4.0 мм хүртэлх цас, хоёр дахь удаа 12 сумын нутагт 0.0-3.0 мм цас орсон бол гурав дахь удаа 9 сумын нутгаар олон жилийн дунджаас 4.1-25.3 миллиметрээр их хур тунадас орсон. Энэ цаг агаарт нөлөөлөх ажлын үр дүнд 5 дугаар сард аймгийн нийт нутгийн 80-90 хувьд хамруулж хур тунадас нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийн тооцвол 161,7 сая төгрөгт хүрсэн. | 100% |
|-----|--|---|-------------|--|----|--|------|

|     |   |  |             |  |   |  |      |
|-----|---|--|-------------|--|---|--|------|
| 155 | 5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. | 1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах | 2021 - 2024 |  | 3 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Бөмбөгөр сум 2 булаг, Галуут сум 2 булгийн эхийг хашиж хамгаалсан. “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн хүрээнд зэрлэг ан амьтны усан хангамжийг сайжруулах зорилгоор Баацагаан сумын Шуудуугийн булаг, Баянцагаан сумын Баянбулаг булаг, Шинэжинст сумын Хаяа булгийн эхийг тус тус хашиж хамгаалсан. Ингэснээр энэ онд нийт 7 булгийн эхийг хашиж хамгаалсан. Жаргалант сумын 1 дүгээр багийн нутаг Будын эх гэх газарт янгир ямааны байршил бүхий бүсэд уулын гуу жалгыг ашиглан зэрлэг амьтдыг усаар хангах зорилгоор 20х15 харьцаатай хөв байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн хүрээнд зэрлэг ан амьтдын ус хангамжийг сайжруулах зорилгоор Баацагаан сумын Товгор багт, Шинэжинст сумын Цагаан сайр нэртэй газар хуучин цооног, Баян-Өндөр сумын Идрэн багт шинээр худаг гарган нарны өргүүртэй болгон тус тус тохижуулсан | 100% |
|-----|---|--|-------------|--|---|--|------|

|     |  |                |  |     |   |      |
|-----|--|----------------|--|-----|---|------|
| 156 | 2. Малчид,<br>нөхөрлөлүүдтэй<br>хамтран байгаль<br>орчноо хамгаалах<br>нөлөөллийн олон талт<br>ажлыг зохион<br>байгуулах | 2021 -<br>2024 |  | 200 | Ангийн бүс нутагтай Өлзийт, Жаргалант, Галуут, Жинст зэрэг сумууд тухайн бүс нутгийг хариуцан хамгаалах чиглэлээр байгуулагдсан нөхөрлөлүүд сумдын Байгаль орчны албатай хамтран биотехникийн арга хэмжээг хамтран тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Мөн Бууцагаан сумын “Дээд Ариусгал” нөхөрлөл шинээр байгуулагдсан бөгөөд гэрчилгээ олгож бүртгэлжүүллээ. Тус нөхөрлөл нь уст цэг, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Бөмбөгөр, Шинэжинст, Жинст, Өлзийт, Жаргалант зэрэг сумд ангийн бүс нутаг болон хариуцан хамгаалан ажилладаг бүс нутгийн нөхөрлөлүүд нь иргэдэд тус сумдын байгаль орчны албатай хамтран сургалт мэдээллийг 280 орчим иргэн болон нөхөрлөлийн иргэдэд мэдээлэл өгөн ажилласан байна. Мөн “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслөөс Шинэжинст сумын малчдын бүлгийн говийн бүсэд мод тарих ажилд 2 га талбайн усалгааны систем, хашаа хамгаалалтын асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлсэн. | 100% |
|-----|--|----------------|--|-----|---|------|

|     |  |   |             |  |   |   |      |
|-----|--|---|-------------|--|---|---|------|
| 157 | 5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна. | 1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах | 2021 - 2024 |  | 3 | Аймгийн хэмжээнд 2023 оны 01-05 дугаар сарын хооронд зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг хэсэгчлэн зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт, Баянбулаг, Жаргалант, Галуут, Бууцагаан, Гурванбулаг, Заг, Жинст, Хүрээмарал, Богд, Шинэжинст, Баян-Овоо, Бөмбөгөр зэрэг нийт 15 сумын нутаг дэвсгэрийг хамруулан зэрлэг амьтдын байршил бүхий газруудад идэш тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлж 36 удаагийн давтамжтай өвс 1423 боодол, хужир 19 тонн, хорголжин 47 шуудай байршуулж биотехникийн арга хэмжээ авсан. Биотехникийн арга хэмжээ авах үед Янгир ямаа-393, Аргаль угалз-96, Буга, согоо-56 тоо толгойг нүдээр үзэж тоолсон. | 100% |
|-----|--|---|-------------|--|---|---|------|

|     |   |   |             |  |    |  |     |
|-----|---|---|-------------|--|----|--|-----|
| 158 | 5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана. | 1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2024 |  | 90 | Орог нуур түйн голын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний II үе шатын 2023 оны жилийн эцсийн биелэлт 17 зорилт, 27 арга хэмжээний хүрээнд 105 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээс хэрэгжсэн ажил-80, хугацаа хүлээгдэж буй ажил-25, нийт 76 хувьтай хэрэгжүүлсэн байна. Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, “Монхидроконстракшн” ХХК-тай хамтран боловсруулж Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын талуудын оролцооны зөвлөл, Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжсэн саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газарт батлуулахаар хүргүүлсэн. | 30% |
|-----|---|---|-------------|--|----|--|-----|

|     |   |   |             |  |    |  |     |
|-----|---|---|-------------|--|----|--|-----|
| 159 | 5.3.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 |  | 70 | <p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг хэлэлцэн батласан. Тус хөтөлбөрийн хэрэгжилт тайлант оны хагас жилийн байдлаар 79,6 хувьтай байна. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тогтолцоог аймгийн хэмжээнд нэвтрүүлж ажилласан. Энэ онд шинээр 14 сум 94 ширхэг ангилан ялгах хогийн сав байршуулсан. Баян-Өндөр, Баянцагаан, Галуут сумдад хоёрдогч түүхий эд худалдан авч, борлуулдаг иргэд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Өлзийт сум энэ оны 06 дугаар сараас эхлэн сар бүрийн сүүлийн долоо хоногийн Бямба гарагийг дахивар худалдан авдаг өдөр болгож нийт 7000 ширхэг шил, 2,4тн дахивар хогийг цуглуулж "Хонгор дуулим" ХХК-д нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. Баянхонгор сум 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс хог хаягдлыг ангилан ялгаж тээвэрлэж эхэлсэн. Уг ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн 80 орчим хувь нь хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшсэн. Энэ оны жилийн эцсийн байдлаар 2844 тн үнс, 12,84 тн хуванцар буюу нийт хог хаягдлын 14,5%-ийг ангилж ялган эдийн засгийн эргэлтэд оруулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 18,0 сая төгрөгийн санхүүжилтээр Эко кэш буюу хуванцар</p> | 70% |
|-----|---|---|-------------|--|----|--|-----|



|     |   |  |             |  |     |  |     |
|-----|---|--|-------------|--|-----|--|-----|
| 160 | 5.3.2. Баянхонгор сумын гэр хорооллыг цэвэр усны болон дулааны шугамд шат дараатайгаар холбоно. | 1. Баянхонгор сумын 4, 5 дугаар багийн гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр ус, дулааны шугам сүлжээнд холбох | 2022 - 2024 |  | 100 | Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний (2, 3, 4, 5, 6, 7, 9-р баг) ажлын зургийг иж бүрнээр нь “ДНТ” ХХК-аар 2022 онд гүйцэтгүүлсэн. Баянхонгор сумын “Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ”-ний ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад “Б-СОФТ” ХХК шалгарсан бөгөөд 2022.04.22-ны өдөр 25,328,313,851 төгрөгийн төсөвтэй 2022/64 дүгээр гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 2022 онд гадна ус, дулаан хангамжийн 1620 м шугам, 2023 онд 1480 м шугам, гадна ариутгах татуурга 2022 онд 2000 м шугам, 2023 онд 4620 м шугам, халаалтын зуухны 15 м x 30 м харьцаатай барилгын суурийн цутгалтын ажил, гадна цэвэр ус 2022 онд 1500 м шугам, 2023 онд 3200 м шугам, УДДТөвийн 12 м x 9 м харьцаатай барилгын суурийн цутгалтын ажил тус тус хийгдсэн. Дээрх хийгдсэн ажлуудад захиалагчийн техникийн хяналтыг 14 удаа хийсэн. | 70% |
|     |   |  |             |  |     |  |     |